# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
# ТУШААЛ

2020 оны 04 сарын 29 өдөр Дугаар А/269 Улаанбаатар хот

Түр заавар шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.3, 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (COVID-19)-ын тандалт, сэргийлэлтийн түр зааврыг нэгдүгээр, хариу арга хэмжээний түр зааврыг хоёрдугаар, тархвар судалгааны хуудсыг гуравдугаар, халдварын батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын тархвар судалгааны хуудсыг дөрөвдүгээр, лабораторийн оношилгооны түр зааврыг тавдугаар, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд мөрдөх халдварын сэргийлэлт, хяналтын түр зааврыг зургаадугаар, иргэнийг тусгаарлах, ажиглах түр зааврыг долоодугаар, халдваргүйжүүлэлт хийх түр зааврыг наймдугаар, голомтот бүс нутгаас агаарын хөлгөөр зорчигч тээвэрлэхэд баримтлах халдвараас сэргийлэх түр зааврыг есдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг ханган, болзошгүй эрсдэлээс сэргийлэх, уг тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Уг тушаалын хэрэгжилтэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/, Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлүүд, тархвар судлалын болон эмнэлзүйн зөвлөх баг, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д үүрэг болгосугай.

4. Уг тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын А/135, А/188 тоот тушаалуудыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Я.Амаржаргал/-д даалгасугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

141200947

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 сарын 29-ны өдрийн А/263 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ТАНДАЛТ, СЭРГИЙЛЭЛТИЙН ТҮР ЗААВАР

## Нэг. Үндэслэл

2019 оны 12 дугаар сарын сүүлчээс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хубей мужийн Ухань хотод шалтгаан тодорхойгүй уушгины хатгаа өвчний дэгдэлт бүртгэгдэж, 2020 оны 1 дүгээр сарын 7-нд шинэ төрлийн коронавирус (SARS-CoV-2)-ээр үүсгэгдсэн болохыг тогтоосон. 2020 оны 1 дүгээр сарын 31-ний байдлаар уг халдвар нь дэлхийн 20 улсыг хамарч эрчимтэй тархсан тул Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас "Олон улсын шинж чанартай нийгмийн эрүүл мэндийн онц байдал" хэмээн зарласан

ДЭМБ-ын мэргэжлийн зөвлөх багийн 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар уг халдварыг "COVID-19" хэмээн нэрлэж, олон улсын өвчний 10 дугаар ангиллаар U07.1 кодоор бүртгэж байна.

2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр "Коронавируст халдвар (COVID-19)-ыг "ЦАРТАХАЛ" гэж зарласан.

ДЭМБ-ын мэдээллээр 2020 оны 4 дүгээр сарын 29-ний байдлаар дэлхийн 213 улсад коронавируст халдвар (COVID-19)-ын 3,137,761 батлагдсан тохиолдол бүртгэгдэж, 217,594 хүн нас барсан ба үхлийн түвшин 6,9% байна. Манай улсад уг халдварын зөөвөрлөгдөн орж ирсэн 38 батлагдсан тохиолдол бүртгэгдсэн байна.

Монгол улсын Шадар сайдын 2017 оны А/08 тоот тушаалаар батлагдсан Эрсдэлийн үнэлгээний аргачлалаар 2020 оны 4-р сарын 17-нд хийсэн хийсэн 7 дах удаагийн салбар хоорондын байгууллагуудын үнэлгээгээр Короновирүст халдварын дэгдэлт Монгол улсад бүртгэгдвэл нөхцөл байдлын эрсдэлийн түвшин "Маш өндөр" гэж үнэлэгдсэн тул коронавируст халдвар (COVID-19)-ын үед шуурхай хариу арга хэмжээ авах, тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Коронавируст халдвар (COVID-19)-тай тэмцэх, сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ энэхүү түр заавар болон бусад холбогдох дүрэм, журмыг баримтална.

ДЭМБ-аас зөвлөмж болгосон коронавируст халдвар (COVID-19)-ын түр заавар шинэчлэгдэх бүрт энэхүү зааварт нэмэлт өөрчлөлт орно.

## Хоёр. Коронавируст халдвар (COVID-19)-ын тархвар судлал

### 2.1. Үүсгэгч

*Coronaviridae* овгийн Бета-коронавирусийн бүлгийн дан утаслаг РНХ агуулсан SARS-CoV-2 вирус.

### 2.2. Үүсгэгчийн гадаад орчинд тэсвэрлэх чадвар

SARS-CoV-2 вирус нь 40%-ийн агаарын чийгшил, цельсийн 21-23°C хэмд зэс, ган, цаас, хуванцар эдлэлийн гадаргууд 7-оос дээш хоног тэсвэртэй. Дэлхийн хэд хэдэн орны лабораторид хийсэн шинжилгээ, туршилтаар үүсгэгч нь тасалгааны хэмд модон болон хөвөн эдлэлийн гадаргууд 24 цаг, арьсан эдлэлд ≥24 цаг, барилгын хананы шохой, цаасанд 36 цаг, хуванцар эдлэлийн гадаргууд 36-72 цаг, ган эдлэлийн гадаргууд 72 цаг, шилэн эдлэлийн гадаргууд 96 цаг хүртэл хадгалагдаж байна.

Өвчтний өтгөн, шээсэнд тасалгааны хэмд 1-2 өдөр, суулгах шинж тэмдэг илэрсэн өвчтний өтгөнд 4 хоног хүртэл хадгалагдаж, өргөн хэрэглээний халдваргүйжүүлэх бодисоор үйлчлүүлсний дараа халдварлуулах идэвх нь богино хугацаанд алдагддаг байна.

## 2.3. Халдварын эх уурхай

Коронавируст халдвар (COVID-19)-аар өвчилсөн өвчтөн.

## 2.4. Халдвар дамжих зам

Дуслын болон хавьтлын замаар халдвар дамжина.

Хамгаалах хувцас, хэрэгсэлгүй эсвэл бүрэн бус хэрэгсэлтэйгээр коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнийг асарч сувилах, эмчилгээ хийх, цагаан мөгөөрсөн хоолойд интубацийн гуурс тавих, авах, бронх дурандах, трахеоэктоми хийх, амьсгал, зүрх зогссон үед сэхээн амьдруулах тусламж, үйлчилгээ үзүүлэх, биед хүрэлцэх, нэг метрээс дотогш зайд харьцах үед ам, хамар, нүдний салст бүрхэвчээр дуслын болон шууд хавьтлын замаар халдвар дамжина. Өвчтөн амны хаалт хэрэглээгүй, амаа халхлаагүй нөхцөлд амьсгалах, ярих, ханиах үед вирус агуулсан халдвартай дусал 1-2 метр хүртэлх зайд агаарт цацагдаж, дуслын замаар халдвар дамжина.

Өвчтэй хүний хэрэглэж байгаа, хэрэглэж байсан эд юмс, биеийн шингэн, эмнэлгийн тусламж үзүүлэх үед ашигласан багаж, тоног төхөөрөмж зэргээр шууд бус хавьтлын замаар халдвар дамжина.

## 2.5. Нууц үеийн хугацаа

Нууц үеийн хугацаа 1-14 хоног

## 2.6. Халдвартай байх үе

Одоогоор тогтоогдоогүй.

## 2.7. Халдварт өртөх эрсдэлтэй хүн ам

Бүх насны хүн ам халдварт өртөх эрсдэлтэй. Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнтэй нэг метрээс дотогш зайд харьцаж, биед нь шууд хүрэлцсэн хүн, тухайн өвчтөнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн ажилтан, нэг тасагт хэвтэн эмчлүүлж байгаа бусад өвчтнүүд, уушгины архаг бөглөрөлт өвчин, ДОХ ба бусад дархлаа дутмагшилтай, хорт хавдартай өвчтөн, зүрх судас, уушги, бөөр, элэг, цус, мэдрэлийн архаг, чихрийн шижин болон бусад суурь өвчтэй, эрхтэн шилжүүлэн суулгуулсан, жирэмсэн, таргалалттай, 60-аас дээш насныхан хүндрэх эрсдэлтэй.

## 2.8. Коронавируст халдвар (COVID-19)-ын тохиолдлын тодорхойлолт

### 2.8.1. Сэжигтэй тохиолдол

А. Биеийн хэм 37.1–ээс дээш, ханиалгах, амьсгаадах зэрэг амьсгалын замын цочмог халдварын шинж тэмдгийн аль нэг илэрсэн, эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс 14 хоногийн өмнө коронавируст халдвар (COVID-19) бүртгэгдэж байгаа улс, орон нутагт аялсан эсвэл оршин суудаг гэсэн өгүүлэмжтэй тохиолдол;

Б. Амьсгалын замын цочмог халдвартай, эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс 14 хоногийн өмнө коронавируст халдвар (COVID-19)-ын батлагдсан эсвэл магадлалтай тохиолдолтой хавьтал болсон хүн, хамгаалах хувцас, хэрэгсэлгүй, бүрэн өмсөлгүйгээр өвчтөнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байсан гэсэн өгүүлэмжтэй эрүүл мэндийн ажилтан;

В. Амьсгалын замын цочмог хүнд халдвартай, 37.1 хэмээс дээш халуурсан, ханиалгах, амьсгаадах зэрэг амьсгалын замын цочмог халдварын аль нэг шинж тэмдэг илэрсэн, зайлшгүй эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх шаардлагатай, илэрч буй эмнэлзүйн шинж тэмдгийн шалтгааныг бүрэн тайлбарлах боломжгүй тохиолдлыг хэлнэ.

### 2.8.2. Магадлалтай тохиолдол

А. Коронавируст халдвар (COVID-19)-ын шинжилгээний дүн тодорхойгүй сэжигтэй тохиолдол эсвэл бусад хэвшинжийн коронавирус зэрэг тодорхойлогдсон, амьсгалын замын өвчний үүсгэгч вирус илрээгүй;

Б. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй боловч тухайн орон нутагт уг халдварыг лабораториор баталгаажуулах чадавхигүйн улмаас шинжилгээ хийлгэх боломжгүй тохиолдлыг хэлнэ.

### 2.8.3. Батлагдсан тохиолдол

Эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн эсэхээс үл хамааран лабораторийн шинжилгээгээр коронавируст халдвар (COVID-19)-тай болох нь тогтоогдсон тохиолдлыг хэлнэ.

### 2.8.4. Ойрын хавьтал

Магадлалтай болон батлагдсан тохиолдолтой эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс 2 хоногийн өмнө болон шинж тэмдэг илэрсэнээс нь хойш 14 хоногийн хугацаанд дараахь байдлаар хавьтал болсон хүнийг ойрын хавьтал гэнэ. Үүнд:

- Нэг метрээс дотогш зайд 15 минутаас доошгүй хугацаанд хамт байсан, хамгаалах хувцас хэрэгсэлгүйгээр эмнэлгийн тусламж үзүүлсэн, өвчтөнг асарсан;
- Хамт байсан гэр бүлийн гишүүд, нэг өрөөнд хамт ажиллагсад болон суралцагсад;
- Нэг тээврийн хэрэгсэл буюу галт тэрэгний нэг купе, нийтийн вагон, автобус, суудлын автомашинд суусан бүх зорчигчид, агаарын хөлгийн урд, хойд, хажуугийн 3 эгнээнд суусан зорчигчид, үйлчилгээ үзүүлсэн ажилтан.

- Эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй боловч батлагдсан тохиолдлын ойрын хавьталд оруулах хугацааг тооцохдоо оношийг баталсан сорьц авсан өдрөөс 2 хоногийн өмнө болон хойш 14 хоногийн хугацаанд дээрхи байдлаар хавьталд орсон хүмүүсийг оруулна.

## Гурав. Коронавируст халдвар (COVID-19)-ын бэлэн байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

### 3.1. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага

3.1.1. Коронавируст халдвар (COVID-19)-тай тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

3.1.2. Коронавируст халдвар (COVID-19)-тай тэмцэх, сэргийлэх арга хэмжээг нэгдсэн зохицуулалтаар хангах ажлын хэсэг, мэргэжлийн зөвлөх баг болон шуурхай хариу арга хэмжээний багийг байгуулах, тохиолдлын удирдлагын тогтолцооны горимоор ажиллах;

3.1.3. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх, тандах, эрт илрүүлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний журам, зааврыг боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулах;

3.1.4. Коронавируст халдвар (COVID-19)-ын тархалт, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар УИХ, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комисс, холбогдох бусад байгууллагыг мэдээллээр хангах;

3.1.5. Коронавируст халдвар (COVID-19)-ын үеийн бэлэн байдлын нөөцийг үнэлэх, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх асуудлыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

3.1.6. Яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, амны хаалт, оношлуур, урвалж, халдваргүйжүүлэх бодисын нөөцийн бэлэн байдлыг хангах;

3.1.7. Хүний нөөцийг дайчлан ажиллуулах төлөвлөлт, ерөнхий заавар, аргачлал, аргазүйгээр хангаж ажиллах;

3.1.8. Эрүүл мэндийн байгууллагуудад хүний нөөцийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах чиглэлээр албан даалгавар, зөвлөмж өгч ажиллах;

3.1.9. Коронавируст халдвар (COVID-19)-ын талаар хүн амыг нэгдсэн мэдээллээр хангах;

3.1.10. Эрсдэлийн мэдээлэл, харилцааны үйл ажиллагааг чиглүүлэх, коронавируст халдвар (COVID-19)-ын талаарх албан ёсны мэдээллээр олон нийтийг хангах;

3.1.11. Коронавируст халдвар (COVID-19)-ын хяналтын самбар, цахим хуудас, хурал, чат бот, калл-про үйлчилгээг нэвтрүүлж, тогтмол үйл ажиллагааг хангах, шинэчлэх;

### 3.2. Халдварт өвчин судлалын үндэсний төв

3.2.1. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх;

3.2.2. Коронавируст халдвар (COVID-19)-ын нөхцөл байдалтай уялдуулан салбар хоорондын байгууллагуудтай хамтран эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн түвшин, идэвхжлийн зэргээс хамаарч, хариу арга хэмжээг зохион байгуулах, тохиолдлын удирдлагын тогтолцооны горимоор ажиллах;

3.2.3.Томуу, томуу төст өвчин болон амьсгалын замын цочмог хүнд халдварын тандалтыг эрчимжүүлэх;

3.2.4. Коронавируст халдвар (COVID-19)-тай тэмцэх, сэргийлэх, тандах, бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээ авах чиглэлээр журам, зааврыг ДЭМБ-ын түр заавар, удирдамжтай уялдуулан боловсруулах;

3.2.5. Үндэсний түвшинд коронавируст халдвар (COVID-19)-тай тэмцэх, сэргийлэх, тандах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний журам, зааврыг хэрэгжүүлэхэд мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах;

3.2.6. Коронавируст халдвар (COVID-19)-ын бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээг эрчимжүүлэх талаар эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэгт хяналт хийх;

3.2.7. Сэжигтэй, магадлалтай тохиолдлыг судлах, батлагдсан тохиолдлын эх уурхай, ойрын хавьтал, голомтын цар хүрээг тодорхойлж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.2.8. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй, магадлалтай тохиолдлоос сорьц цуглуулж, лабораториор баталгаажуулах;

3.2.9. Шинэ болон дахин сэргэж байгаа халдварын болон тусгай тасгийн бэлэн байдлыг хангаж, эмнэлгийн орны зохицуулалт хийн, нэмэлтээр ор дэлгэж, сэжигтэй болон батлагдсан тохиолдлуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

3.2.10. Коронавируст халдвар (COVID-19)-ын голомтод ажиллах шуурхай хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулах, сургах, хамгаалах хувцас, хэрэгслээр тасралтгүй хангах;

3.2.11. Коронавируст халдвар (COVID-19)-ын өвчлөлийн байдалд дүн шинжилгээг тогтмол хийж, хариу арга хэмжээг төлөвлөх, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах;

3.2.12. Коронавируст халдвар (COVID-19)-ын дэгдэлтийн үед дайчлагдан ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх, сургалт зохион байгуулах;

3.2.13. Тусгаарлах, ажиглах байрны халдвар хамгааллын дэглэмийн байдалд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

3.2.14. Аймаг, нийслэл, хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсийн улсын байцаагч, ажилтанд халдвараас сэргийлэх дэглэм, хариу арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.2.15. Халдварын сэжигтэй тохиолдол агаарын хилийн боомт, олон улсын төмөр зам, гаалийн хяналтын бүсэд илэрсэн үед мэргэжлийн багийг илгээж, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд орон нутагт мэргэжлийн багийг илгээх;

3.2.16. Коронавируст халдвар (COVID-19)-ын тандалт, оношилгоо, эмчилгээний талаарх сургалтыг эрүүл мэнд, мэргэжлийн хяналт болон холбогдох байгууллагыг оролцуулан зохион байгуулах;

3.2.17. Коронавируст халдвар (COVID-19)-ын талаарх албан ба албан бус мэдээллийг шүүх, иргэдэд мэдээлэл өгөх 8008-6829 утсыг 7/24 цагаар ажиллуулж, иргэдээс ирүүлж буй мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ташаа мэдээллийг залруулах, олон нийтийн хандлагыг судлах;

3.2.18. Хүн амд зориулсан мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх, тогтмолжуулах;

**3.3. Зоонозын өвчин судлалын үндэсний төв**

3.3.1. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, тохиолдлын удирдлагын тогтолцооны горимоор ажиллах;

3.3.2. Халдварт өвчний бэлэн байдлын улсын хэмжээний нөөцийг бүрдүүлэх, шаардлагатай үед нөхөн хангалт хийх;

3.3.3. Батлагдсан тохиолдлын тэжээвэр болон гэршсэн амьтдын дунд мал эмнэлгийн болон бусад холбогдох байгууллагатай хамтран тандалт судалгаа хийх;

3.3.4. Коронавируст халдвар (COVID-19)-ын дэгдэлтийн үед дайчлагдан ажиллах хүний нөөцийг чадавхижуулах, сургалт зохион байгуулах;

3.3.5. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй тохиолдлыг тээвэрлэн ирсэн онгоц, галт тэрэг бусад тээврийн хэрэгсэл, зорчигчдын эд зүйлс, ачаа тээш, хатуу, шингэн хог хаягдалд эцсийн халдваргүйжүүлэлт хийж, устгал хийх байгууллагад хүлээлгэн өгнө.

3.3.6. Сэжигтэй болон батлагдсан тохиолдлын голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийх, шаардлагатай тохиолдолд тархвар судлалын заалтаар халдваргүйжүүлэлт хийх;

3.3.7. Вирусын эсрэг үйлчилгээтэй халдваргүйжүүлэх бодисын нөөцийг гарган, бэлэн байдлыг хангах, хэрэглэх зааврыг боловруулах;

3.3.8. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед хийгдэх халдваргүйжүүлэлтийн талаар эрүүл мэндийн болон салбар хоорондын байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах;

3.3.9. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх талаар хүн амд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа хийх;

3.3.10. Вирус судлалын лабораторийн бэлэн байдлыг хангах, лабораторийн шинжилгээ хийх;

3.3.11. Коронавируст халдвар (COVID-19)-ын голомтод ажиллах шуурхай хариу арга хэмжээний болон тусламж, үйлчилгээний багийг томилон ажиллуулах, сургах, хамгаалах хувцас, хэрэгслээр тасралтгүй хангах;

3.3.12. Коронавируст халдвар (COVID-19)-ын дэгдэлтийн үед дайчлагдан ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх, сургалт зохион байгуулах;

3.3.13 Коронавируст халдвар (COVID-19)-ын талаарх албан ба албан бус мэдээллийг шүүх, иргэдэд мэдээлэл өгөх 70284393 утсыг 7/24 цагаар ажиллуулж, иргэдээс ирүүлж буй мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ташаа мэдээллийг залруулах, олон нийтийн хандлагыг судлах;

3.3.14. Хүн амд зориулсан мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх, тогтмолжуулах;

**3.4. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв**

3.4.1. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, тохиолдлын удирдлагын тогтолцооны горимоор ажиллах;

3.4.2. Коронавируст халдварын талаарх хүн амын дундах ойлголт, хандлагыг тандаж, тухай бүр нь хариу арга хэмжээ авах;

3.4.3. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд дүн шинжилгээ хийж, тайлбар, мэдээлэл хийх;

3.4.4. Коронавируст халдвар (COVID-19)-ын дэгдэлтийн үед дайчлагдан ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх, сургалт зохион байгуулах;

3.4.5. Эрсдэлийн харилцаа холбоог эрчимжүүлж, өдөр тутмын нөхцөл байдалтай уялдуулан зөвлөмж, сэрэмжлүүлэг гарган түгээх;

3.4.6. Коронавируст халдвар (COVID-19)-ын талаар иргэдэд мэдээлэл өгөх 119 дугаарын утсыг 24 цагаар ажиллуулах;

3.4.7. Хүн амд зориулсан мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх, тогтмолжуулах.

**3.5. Эрүүл мэндийн хөгжлийн төв**

3.5.1. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, тохиолдлын удирдлагын тогтолцооны горимоор ажиллах;

3.5.2. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед дайчлах хүний нөөцийн судалгааг гаргах;

3.5.3. Коронавируст халдвар (COVID-19)-ын тандалт, сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, халдварын сэргийлэлт, хяналт, сэтгэл зүйн чиглэлээр сургалтын төлөвлөгөө гаргах, ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ-тэй хамтран сургалт зохион байгуулах;

3.5.4. Үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцагч резидент эмч нарын дэлгэрэнгүй судалгааг гаргаж, дайчилгааны бэлэн байдлыг хангах;

3.5.5. Тусгаарлан ажиглах байранд ажиллах резидент эмч нарыг хуваарилах, мэргэжил арга зүйгээр хангах, сургалтад хамруулах;

3.5.6. Ажиглалтад байгаа иргэдийн эрүүл мэндийн талаарх мэдээ, мэдээллээр шийдвэр гаргагчдыг хангах;

3.5.7. Тусгаарлан ажиглах байранд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоог гаргах, хангалт хийх;

3.5.8. Тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй бусад ажилчдад сургалт зохион байгуулах;

3.5.9. Тусгаарлан ажиглах байранд буй иргэдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх;

3.5.10. Эрүүл мэндийн байгууллагын Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг гаргах;

3.5.11. Коронавируст халдвар (COVID-19)-тай холбоотой статистик мэдээ, мэдээллийг цуглуулах, нэгтгэх, тайлагнах, архивлах.

### 3.6. Эрүүл мэндийн байгууллага

3.6.1. Коронавируст халдвар (COVID-19)-тай тэмцэх, сэргийлэх, бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, тохиолдлын удирдлагын тогтолцооны горимоор ажиллах;

3.6.2. Томуу томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдварын тандалтыг эрчимжүүлэх;

3.6.3. Хариу арга хэмжээ, халдварын сэргийлэлт, хяналтын багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх;

3.6.4. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй тохиолдлыг тусгаарлах, эмчлэх өрөөг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын 9 дүгээр хавсралтын дагуу зохион байгуулах;

3.6.5. Халдварын сэжигтэй тохиолдол харьяа нутаг дэвсгэр, хилийн боомтод илэрвэл мэргэжлийн багийг илгээж, хариу арга хэмжээг салбар хоорондын байгууллагатай хамтран шуурхай авч хэрэгжүүлэх;

3.6.6. Хөтөч ажилтанг ажиллуулж, халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг үзлэгийн өрөөнд байрлуулж, хариу арга хэмжээг зохион байгуулах;

3.6.7. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд амны хаалт зүүх, гарын эрүүл ахуй сахих, зөв ханиаж, найтаах санамж, анхааруулгыг өгөх;

3.6.8. Амбулатори, хүлээн авах, яаралтай тусламжийн хэсэгт хэт ачаалал үүсэхээс сэргийлж, эмнэл зүйн шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг бусад үйлчлүүлэгчээс тусад нь хүлээн авах бүстэй байхаар зохион байгуулах;

3.6.9. Коронавируст халдвар (COVID-19)-ыг эрт илрүүлэх, оношлох чиглэлээр эрүүл мэндийн ажилтан бүрийг сургах;

3.6.10. Халдварын сэргийлэлт, хяналтын байнгын болон нэмэлт сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.6.11. Эрүүл мэндийн ажилтанг коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлж, хамгаалах хувцас, хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодисоор хангах;

3.6.12. Коронавируст халдвар (COVID-19)-ын голомтод байнгын болон эцсийн халдваргүйжүүлэлт хийх;

3.6.13. Эрүүл мэндийн байгууллагын орчинд гар угаах, халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.6.14. Эрүүл мэндийн ажилтанд анхааруулга, сэрэмжлүүлэг өгөх зорилгоор илрэх шинж тэмдэг, тохиолдлын тодорхойлолтыг хэвлүүлэн нүдэнд харагдахуйцаар байршуулах;

3.6.15. Харьяалагдах хүн ам, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа хийх;

### 3.7. Иргэний агаарын болон төмөр зам, нийтийн тээврийн газар

3.7.1. Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж хэрэгжүүлэх;

3.7.2. Нисэх онгоцны буудал, авто, төмөр замын зорчигч үйлчилгээний төвүүдэд коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөө, галт тэрэг, агаарын хөлөгт тусгаарлах хэсгийг бэлтгэж, бэлэн байдлыг хангах;

3.7.3. Зорчигч тээврийн байгууллагууд аяллын явцад зорчигчдын эрүүл мэндэд хяналт тавьж, сэжигтэй тохиолдол илэрсэн үед холбогдох байгууллагад даруй мэдээлж, зохих хариу арга хэмжээ авах;

3.7.4. Халдвар бүртгэгдсэн улс, орон нутаг руу аялал хийх тээврийн хэрэгслийн багийг хамгаалах хувцас, хэрэгсэл, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодисоор хангах;

3.7.5. Ажиллагсдад урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн дэглэм сахих талаар сургалт зохион байгуулж, амны хаалт, гар халдваргүйжүүлэх бодисоор тогтмол хангах;

3.7.6. Үйлчлүүлэгчдэд бие засах, гар угаах нөхцөлийг бүрдүүлж, үйлчилгээний танхим, ариун цэврийн өрөөнд гар халдваргүйжүүлэгч бодисыг хүрэлцэхүйц тоо, хэмжээгээр байршуулах;

3.6.7. Мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг урсдаг цахим самбар болон бусад хэлбэрээр байршуулах, зорчигчдод халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж өгөх;

3.6.8. Үйлчлүүлэгчдийн биеийн халууныг зайнаас хэмжиж, амны хаалт зүүсэн зорчигчдод үйлчилгээг үзүүлэх;

### 3.8. Хилийн нэвтрэх цэгт

3.8.1. Хилийн нэвтрэх цэгт коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх, хариу арга хэмжээ авах бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.8.2. Хилийн нэвтрэх цэгт сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн төхөөрөмж, бодис, эмийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах;

3.8.3. Агаарын хилийн боомт дээр APIC цахим программын тусламжаар зорчигчийн мэдээллийг урьдчилан авч, хариу арга хэмжээг төлөвлөх;

3.8.4. Онгоцны экипажийн даргаас зорчигчийн эрүүл мэндийн ерөнхий мэдүүлэг, галт тэрэгний дарга, автобус, автомашины жолоочоос зорчигчийн тоо, суудлын дугаар бүхий нэрсийн жагсаалтыг тус тус авч, хариу арга хэмжээг төлөвлөх;

3.8.5. Хилээр нэвтэрч буй зорчигчдоос "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг"-ийн хуудсаар аяллын явцад болон хил нэвтрэхээс өмнө асуумж авч, гүйцэд бөглөгдсөн эсэхэд хяналт тавих;

3.8.6. Зорчигчдод эрүүл мэндэд ажиглалт, тандалт хийж, биеийн халууныг суурин төхөөрөмж болон зайнаас хэмжигч багаж хэрэгслээр хэмжих;

3.8.7. Сэжигтэй зорчигч илэрсэн үед түр тусгаарлаж, 10 минутын давтамжтайгаар халууныг 3 удаа хэмжиж баталгаажуулан, холбогдох байгууллагад шуурхай мэдээлэн, нийслэлд ХӨСҮТ-ийн мэргэжлийн баг, аймаг, орон нутагт эмнэлгийн байгууллагыг дуудан шилжүүлэх арга хэмжээ авах;

3.8.8. Ойрын хавьтлыг бүртгэн тогтоож, түр тусгаарлан, биеийн халууныг давтан хэмжиж, ХӨСҮТ-д болон аймаг, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх;

3.8.9. Тээврийн хэрэгслийн бие бүрэлдэхүүн болон шаардлагатай тохиолдолд бусад зорчигчийн биеийн халууныг давтан хэмжиж, халуурах болон бусад шинж тэмдэг илэрвэл эрүүл мэндийн байгууллагад хандах талаар зөвлөгөө өгөх;

3.8.10. Галт тэргэнд сэжигтэй тохиолдол илэрвэл тухайн зорчигчийн суусан тасалгаа /купе/ болон тухайн вагон, автобус, суудлын автомашины бүх зорчигчид, нисэх онгоцонд сэжигтэй зорчигчийн урд, ард, хажуу тус бүр 3 эгнээний хүмүүсийг "ойрын хавьтал" гэж үзэн амны хаалт зүүлгэж, түр тусгаарлах;

3.8.11. Сэжигтэй тохиолдол болон ойрын хавьтлыг эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэн хүлээлцсэн тухай хүснэгт 1-д заасан тэмдэглэлийг үйлдэж, мэдээллийг 2 цагийн дотор холбогдох байгууллагад хүргүүлэх;

3.8.12. Сэжигтэй зорчигч, ойрын хавьтал, бусад зорчигчдын "Эрүүл мэндийн мэдүүлэг"-ийн хуудсаар авсан дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэн, 8 цагийн дотор холбогдох байгууллагад илгээх;

3.8.13. Сэжигтэй зорчигч, ойрын хавьтлыг эмнэлгийн байгууллагад шилжүүлсний дараа тээврийн хэрэгсэл, түр тусгаарлах өрөө, ачаа, тээш, хатуу, шингэн хог хаягдлын эцсийн халдваргүйжүүлэлтийг ЗӨСҮТ-өөр, орон нутагт ЗӨСТ болон зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хяналт тавих;

3.8.14. Хилийн боомтын цогцолборын өрөө, тасалгаа, зорчигч, үйлчилгээний төвийн халдваргүйтгэл, шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих;

3.8.15. Халдварын сэжигтэй материал, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүнийг халдвар эсэргүүцэх дэглэмийн дагуу устгуулах арга хэмжээ авах;

3.8.16. Тухайн халдварын талаарх зөвлөмж, сэрэмжлүүлэг мэдээллээр зорчигч, жолооч, агаарын хөлөг, галт тэрэг, автомашины багийн бүрэлдэхүүн, хил, хяналтын болон бусад хамтран ажилладаг байгууллагыг тогтмол хангаж ажиллах;

3.8.17. Үүссэн нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагатай эрсдэлийн харилцаа холбоо үүсгэн, шаардлагатай мэдээллээр хангах;

3.8.18. Шаардлагатай тохиолдолд хорио цээрийн хязгаарлалтын дэглэм зөрчсөн, "Эрүүл мэндийн мэдүүлэг"-ийг бөглөхөөс татгалзсан, санаатайгаар худал бөглөсөн хувь хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийг үндэслэн хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авах;

3.8.19. Хил залгаа хөрш улсын боомтын хорио цээрийн байгууллагад өвчний талаарх мэдээллийг хүргүүлж, хамтарсан арга хэмжээг авах;

3.8.20. Тухайн нөхцөл байдал нь гаалийн хяналтын бүс, талбай /терминал/-д үүсвэл энэхүү зааврын дагуу хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.8.21. Зорчигчийн биеийн халууныг зайнаас хэмжих төхөөрөмжийг /термокамер/ хүртээмжтэйгээр байрлуулах, үйл ажиллагааны хэвийн байдлыг 2 долоо хоног тутамд хянаж, баталгаажуулах;

3.8.22. Монгол улсын хилээр гарч буй зорчигч /жолооч/-оор "Эрүүл мэндийн мэдүүлэг" хуудсыг бөглүүлэн, биеийн халууныг хэмжиж, сэжигтэй тохиолдол илэрвэл буцаах арга хэмжээ авч, эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх;

3.8.23. "Эрүүл мэндийн мэдүүлэг"-ийн хуудсыг монгол, англи хэл дээр, шаардлагатай тохиолдолд орос, хятад, япон, солонгос, казак хэл дээр хөрвүүлж ашиглах;

3.8.24. Зорчигчдоор бөглүүлсэн "Эрүүл мэндийн мэдүүлэг"-ийн хуудсыг зургаар баталгаажуулж, халдвараас сэргийлэх дэглэмийн дагуу устгуулах, зорчигчдын гадаад паспортыг мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэхэд хяналт тавих;

3.8.25. Коронавируст халдвар (COVID-19)-тай болох нь батлагдсан тохиолдлыг эдгэрсэн тухай эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хяналт тавьж, улсын хилээр нэвтрүүлэх;

3.8.26. Хэрэглэсэн хамгаалах хувцас, хэрэгсэл болон бусад хатуу, шингэн хог хаягдлыг зориулалтын уутанд цуглуулж, зохих зөвшөөрөлтэй устгалын байгууллагад шилжүүлж, устгуулах;

3.8.27. Зорчигчдод эрүүл мэндийн тандалт судалгаа хийх, сэжигтэй тохиолдол, ойрын хавьтлыг илрүүлэх зэрэг арга хэмжээнд шаардлагатай тохиолдолд харъяа байгууллагаас улсын байцаагчдыг дайчлан ажиллуулах;

3.8.28. Зорчигчдыг эрэмбэлэн ангилах, сэжигтэй зорчигчийг илрүүлэх, ойрын хавьтлыг тогтоож тусгаарлалтад шилжүүлэх үйл ажиллагаанд оролцсон холбогдох байгууллагын ажилтан тус бүрийн мэдээллийг бүртгэж, биеийн халууныг хэмжих зэрэг эрүүл мэндийн тандалт хийх;

3.8.29. Хүний нөөцийн тасралтгүй үйл ажиллагааг бүрдүүлж, улсын байцаагчдын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах;

3.8.30. Халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр мэргэжлийн болон хил, хяналтын байгууллагатай хамтран сургалт, сурталчилгаа, дадлага сургуулилтыг зохион байгуулах;

## Дөрөв. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй, батлагдсан тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, тайлагнах

4.1. Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдвартай өвчтөнд илэрч буй эмнэлзүйн шинж тэмдгүүд нь коронавируст халдварын сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирч байгаа эсэхийг үнэлэх;

4.2. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй тохиолдлыг илрүүлсэн эрүүл мэндийн ажилтан нь өвчтөнийг тусгаарлаж, эрүүл мэндийн байгууллагын удирдлагад мэдээлэх;

4.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг эрүүл мэндийн бүх байгууллагад сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед яаралтай тусгаарлаж, Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/-ийн 100 тоот утас болон Нийслэлийн эрүүл мэндийн газар /ЭМГ/-т мэдээлэх;

4.4. Орон нутагт сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед яаралтай тусгаарлаж, аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвд мэдээлэх;

4.5. Аймаг, нийслэлийн ЭМГ сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгж /ШУН/-д 8008-6829 дугаарын утсаар 7/24 цаг болон eop@nccd.gov.mn цахим хаягаар 2 цагийн дотор мэдээлэх;

4.6. ХӨСҮТ-ийн ШУН мэдээллийг хүлээн авч, анхны мэдээллийг ЭМЯ-ны Олон нийттэй харилцах тандалт, шуурхай удирдлагын хэлтэс /ОНХТШУХ/-ийн 51-261629, хариуцлагатай жижүүрийн 31-323002 утсаар тус тус мэдээлэх;

4.7. Мэдээллийн дагуу орон нутагт аймгийн ЭМГ болон нэгдсэн эмнэлэг, БОЭТ, сум, тосгоны ЭМТ, нийслэлд ХӨСҮТ, ЗӨСҮТ, нийслэлийн ЭМГ-ын шуурхай хариу арга хэмжээний баг ажиллан, тандалт судалгаа хийж, сорьц авах; (5-р хавсралтын хүснэгт 2).

4.8. Шуурхай хариу арга хэмжээний баг нь сэжигтэй тохиолдолд эмчийн үзлэг хийж, тархвар судлалын судалгааны хуудасны дагуу мэдээлэл цуглуулан, ойрын хавьтлыг тогтоож, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.9. Хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээс хойш сэжигтэй, батлагдсан тохиолдол болон ойрын хавьтлын талаарх мэдээллийг ХӨСҮТ-өөс бэлтгэн хүргүүлсэн өвчтний жагсаалтад (linelist) шивж оруулан, ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгжийн eop@nccd.gov.mn хаягаар яаралтай хүргүүлэх;

4.10. ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгж нь дээрх мэдээллийг нэгтгэн, Эрүүл мэндийн яамны eochealth2014@gmail.com цахим хаягаар хүргүүлэх;

4.11. ЭМЯ-ны Олон нийттэй харилцах, тандалт, шуурхай удирдлагын хэлтсээс Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар зэрэг холбогдох байгууллагуудад мэдээг цахимаар хүргүүлэх;

4.12. ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгж нь коронавируст халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдол, тандалт, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар өдөр тутмын болон долоо хоног тутмын нэгтгэсэн мэдээлэл бэлтгэн гаргах;

4.13. ХӨСҮТ нь коронавируст халдвар (COVID-19)-ын батлагдсан тохиолдлын мэдээллийг 24 цагийн дотор ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсэд хүргүүлэх;

4.14. Коронавируст халдвар (COVID-19)-ын батлагдсан тохиолдлыг сар бүрийн сүүлчийн өдрөөр тасалбар болгон халдварт өвчнийг мэдээлэх журмын дагуу Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвд мэдээлэх.

Хүснэгт 1. Сэжигтэй тохиолдол болон ойрын хавьтлыг хилийн нэвтрэх цэгт эмнэлгийн байгууллагад шилжүүлэн хүлээлцсэн тухай тэмдэглэл

20.....оны .....сарын.....-ны өдөр №.... Аймаг, нийслэл .................................

| № | Асуулт | | Бөглөх хэсэг |
|---|---|---|---|
| **А.Ерөнхий мэдээлэл** | | | |
| 1. | Хилийн боомт, гаалийн хяналтын бүсийн нэр | | |
| 2. | Тээвэрлэлт, аяллын чиглэл | | |
| 3. | Тээврийн хэрэгслийн хилийн боомтоор нэвтэрсэн, гаалийн хяналтын бүсэд ирсэн цаг, минут | | |
| 4. | Тээврийн хэрэгслийн төрөл, дугаар | | |
| 5. | Тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүний тоо | Экипаж, үйлчлэгч | |
| 6. | | Галт тэрэгний дарга/ үйлчлэгч | |
| 7. | | Жолооч | |
| 8. | Нийт зорчигчийн тоо | | |
| 9. | Үүнээс | Гадаад | |
| 10. | | Монгол | |
| 11. | Сэжигтэй тохиолдлын тоо | | |
| 12. | Ойрын хавьтлын тоо | | |
| **Б.Сэжигтэй тохиолдол болон ойрын хавьтлын мэдээлэл** | | | |
| 13. | Овог | | |
| 14. | Нэр | | |
| 15. | Нас | | |
| 16. | Хүйс | | |
| 17. | Регистрийн дугаар | | |
| 18. | Иргэншил | | |
| 19. | Сүүлийн 14-21 хоногт зорчсон улс | | |
| 20. | Дамжин өнгөрсөн улсуудын нэр | | |
| 21. | Илэрсэн шинж тэмдэг | Биеийн халууны хэм /3 удаагийн хэмжилт хийх/ | |
| 22. | | Бусад шинж тэмдэг | |
| **В. Сэжигтэй тохиолдол болон ойрын хавьтлыг шилжүүлсэн тэмдэглэл** | | | |
| 23. | Шилжүүлсэн ЭАХХХ-ын улсын байцаагч | Овог, нэр | |
| 24. | | Холбоо барих утасны дугаар | |
| 25. | | Гарын үсэг | |
| 26. | Хүлээн авсан эрүүл мэндийн байгууллагын нэр | | |
| 27. | Хүлээн авсан тархвар судлаач | Овог, нэр | |
| 28. | | Холбоо барих утасны дугаар | |
| 29. | | Гарын үсэг | |
| 30. | Байлцсан албан тушаалтан | Овог, нэр | |
| 31. | | Холбоо барих утасны дугаар | |
| 32. | | Гарын үсэг | |
| 33. | Шилжүүлсэн цаг, минут | | |

Жич: Тэмдэглэлийг 2 хувь үйлдэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны
04.сарын 29..-ны өдрийн А/269 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТҮР ЗААВАР

## Нэг. Хариу арга хэмжээний зохион байгуулалт

1.1. Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд коронавируст халдвар (COVID-19)-ын үед хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ дараах шуурхай хариу арга хэмжээний баг (цаашид баг гэх)-ийг зохион байгуулж ажиллах;

1.2. Байгууллагын удирдлагууд багийн гишүүдийг хамгаалах хувцас, хэрэгсэл, тархвар судлалын болон сорьцны дагалдах хуудас, сорьц цуглуулах, тээвэрлэхэд шаардлагатай болон бусад багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах, ажил, амралтын цагийг зохицуулах, үйл ажиллагааг бусад багтай нийцүүлж, хамтран ажиллах, мэдээ, мэдээлэл солилцох ажлыг хариуцан, багийг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангах

- 1.2.1. Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж буй сум, тосгоны эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төв, тусгай эмнэлэгт 2-оос доошгүй баг;
- 1.2.2. Аймгийн түвшинд эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг эсвэл бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хамтарсан 3-аас доошгүй баг;
- 1.2.3. Нийслэлийн түвшинд өрхийн эрүүл мэндийн төвд 2-оос доошгүй баг, дүүрэг бүрт нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн хамтарсан 3-аас доошгүй баг;
- 1.2.4. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлэг (лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлж байгаа)-т тус бүр 2-оос доошгүй баг;
- 1.2.5. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага хүний нөөц, хүчин чадлаас хамаарч 2-оос доошгүй баг;

1.3. Багт ажиллах эрүүл мэндийн ажилтныг сонгохдоо эрүүл мэнд, хүндэтгэн үзэх шалтгаантай (гэр бүлийн гишүүдийн аль нэг нь байнгын асаргаанд байдаг, өрх толгойлсон эцэг, эх гэх мэт) эсэх талаарх нарийвчилсан судалгаанд үндэслэх;

1.4. Багийн гишүүдийн цээжний рентген зургийг авч хянах, лабораторийн шинжилгээнд давтан хамруулах;

1.5. Ажил үүргийн хуваарийг гаргаж, багийн гишүүн бүрт танилцуулж, гарын үсэг зуруулах;

1.6. Багийн гишүүдийн аюулгүй байдлыг хангах, халдварын сэргийлэлт, хяналт, тандалт, оношилгоо, эмчилгээний талаарх сургалтад тасралтгүй хамруулах;

## Хоёр. Багийн бүрэлдэхүүн, чиг үүрэг

2.1. Баг нь багийн ахлагч, тархвар судлагч, их эмч, лабораторийн эмч эсвэл лаборант, ариутгагч, жолооч нарын бүрэлдэхүүнтэйгээр, багийг тархвар судлагч ахлах; сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн хариу арга хэмжээний багийг их эмч ахлах;

2.2. Баг нь сэжигтэй тохиолдолд эмчийн үзлэг хийж, тархвар судалгааны хуудасны дагуу мэдээлэл цуглуулан, ойрын хавьтлыг тогтоож, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.3. Багийн гишүүд хамгаалах хувцас, хэрэгслийг бүрэн, зөв өмсч, тайлсан эсэх, байр, орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын устгалын явцыг хяналтын хуудсаар хянах;
2.4. Багийн гишүүдийн биеийн халууныг өдөрт 2 удаа үзэж, тэмдэглэл хөтлөх;
2.5. Багийн гишүүд дараах үүргийг гүйцэтгэнэ.

**2.5.1. Багийн ахлагч**
2.5.1.1.Багийн гишүүдийн гишүүдийн хамгаалах хувцас, хэрэгсэл, бусад шаардлагатай эд зүйлсээр хангах, зохицуулалт хийх, үйл ажиллагааг бусад багтай нийцүүлж, хамтран ажиллах, мэдээ, мэдээлэл солилцох ажлыг хариуцан, багийг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангах;
2.5.1.2. Сэжигтэй тохиолдлын дуудлагыг хүлээн авмагц багийн гишүүдийг ажлын өдөр 30 минут, амралтын өдөр 1 цагийн дотор бүрдүүлж, бэлэн байдлыг ханган, хариу арга хэмжээг эхлүүлэх;
2.5.1.3. Шууд удирдах албан тушаалтныг нөхцөл байдал, хариу арга хэмжээний талаарх мэдээллээр хангаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт баг ажиллуулах талаар хүсэлт тавьж, шийдвэрлүүлэх;
2.5.1.4. Өвчтөн, түүний ойрын хавьтлыг тусгаарласан тухай мэдээллийг аймгийн ЭМГ, дүүргийн ЭМТ-ийн холбогдох мэргэжилтэнд мэдээлэх;
2.5.1.5. Багийн хариу арга хэмжээний илтгэх хуудсыг бичиж, сэжигтэй, батлагдсан тохиолдол болон хавьтлын тархвар судалгааны хуудас, лабораторийн шинжилгээний дүн зэргийг бүрэн бөглөсөн эсэхийг хянаж, шууд удирдах албан тушаалтанд хүргүүлэх;
2.5.1.6.Хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээс хойш сэжигтэй, батлагдсан тохиолдол болон ойрын хавьтлын талаарх мэдээллийг ХӨСҮТ-өөс бэлтгэн хүргүүлсэн лайнлистэд шивж оруулан ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгжийн eop@nccd.gov.mn хаягаар 24 цагийн дотор хүргүүлэх;

**2.5.2. Тархвар судлагч**
2.5.2.1. Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдол болон ойрын хавьтлаас тархвар судлалын асуумжаар судалгаа авч, тандалт хийн, их эмч, багийн ахлагчтай зөвлөлдөн, ажиглах, тусгаарлах эсэхийг шийдвэрлэх;
2.5.2.2. Ойрын хавьтлыг 14 хоногийн хугацаанд гэрт нь тусгаарлаж, харьяалах сум, өрхийн эмчийн хяналтад шилжүүлэх;
2.5.2.3. Сум, өрхийн эрүүл мэндийн ажилтанд мэргэжил, аргазүйн зөвлөмж, өвчтөн болон ойрын хавьталд зөвлөгөө өгөх;
2.5.2.4. Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдлын биеийн байдал хөнгөн, дунд бол дотуур утас, гар утас, камер, дуудлагын систем зэргийг ашиглан асуумж авна. Хэрэв өвчтний биеийн байдал хүнд эсвэл нас барсан бол гэр бүл, асран хамгаалагч, ойр дотны хүнээс асуумж авах;
2.5.2.5. Сэжигтэй, батлагдсан тохиолдол болон ойрын хавьтлын талаарх мэдээллийг ХӨСҮТ-өөс бэлтгэн хүргүүлсэн лайнлистэд шивж оруулан багийн ахлагчид цахимаар хүргүүлэх;

2.5.2.6. Сэжигтэй, батлагдсан тохиолдол болон хавьтлын тархвар судалгааны хуудас, лабораторийн шинжилгээний дүн зэргийг бүрэн бөглөж, тухайн өдөр хийсэн ажлын илтгэх хуудасны хамт багийн ахлагчид хүлээлгэн өгөх;
2.5.2.7. Батлагдсан тохиолдлыг эмчилж байгаа эмч нь өвчтнөөс 14, 21 дэх хоногт тархвар судлалын судалгааны хуудсаар давтан асуумж, судалгаа авч, хариу арга хэмжээний багийн тархвар судлагч эмчид хүлээлгэн өгөх;

**2.5.3. Их эмч**
2.5.3.1 Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдол, ойрын хавьталд үзлэг хийж, эрэмбэлэн ангилалт хийх;
2.5.3.2. Тархвар судлагч эмч, багийн ахлагчтай зөвлөлдөн тусгаарлах эсэхийг шийдвэрлэж, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлэх;
2.5.3.3. Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдлыг харьяалах эмнэлэгт урьдчилан мэдэгдэж, хүлээлгэж өгөх;

**2.5.4. Лабораторийн эмч эсвэл лаборант**
2.5.4.1. Сэжигтэй, магадлалтай тохиолдлоос сорьц авч, холбогдох журмын дагуу хадгалж, тээвэрлэн ХӨСҮТ эсвэл харьяалах вирус судлалын лабораторид хүргүүлнэ. Сорьц илгээх тухай мэдээллийг лабораторийн эрхлэгч, ажилтанд урьдчилан мэдэгдэх;
2.5.4.2. Тухайн өдөр хийсэн ажлын илтгэх хуудсыг багийн ахлагчид хүлээлгэн өгөх;

**2.5.5. Ариутгагч**
2.5.5.1. Голомтод эцсийн халдваргүйжүүлэлтийг тархвар судлагч эмчийн хяналтан дор хийж, тэмдэглэл хөтлөх;
2.5.5.2. Хариу арга хэмжээ авсны дараа тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх;
2.5.5.3.Тухайн өдөр хийсэн ажлын илтгэх хуудсыг багийн ахлагчид хүлээлгэн өгөх;

**2.5.6. Жолооч**
2.5.6.1. Машины бэлэн байдал, багийн гишүүдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах;
2.5.6.2. Тархвар судлагч эмчийн хяналтан дор хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөж тайлах;

## Гурав. Өвчтөн өөрөө эрүүл мэндийн байгууллагад хандсан үед авах хариу арга хэмжээ

3.1. Үзлэгийн явцад коронавируст халдвар (COVID-19) гэж сэжиглэсэн тохиолдолд эмч тухайн өрөө (гэр)-нөөс гарах, орох хөдөлгөөнийг хориглоно. Өрөө (гэр)-нд байгаа бүх хүнд амны хаалт зүүлгэж, сэжигтэй тохиолдлоос 1 метрээс дотогш зайд харьцахгүй байхыг анхааруулж, удирдлагад шууд мэдээлэх;
3.2. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага нь мэдээг хүлээн авч, байгууллагын гарах, орох, хөдөлгөөнийг түр зогсооно. Сэжигтэй тохиолдолд үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлж байгаа иргэнийг бүртгэх, голомтыг халдваргүйжүүлэх арга хэмжээг зохион байгуулах;
3.3. Сэжигтэй өвчтнийг түр тусгаарлах өрөө эсвэл тасагт тусгаарлах;

3.4. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага шуурхай арга хэмжээний багийг дуудаж, үүрэгжүүлэх;
3.5. Баг нь сэжигтэй тохиолдлын ойрын хавьтлыг тогтоон, голомтод халдваргүйжүүлэлт хийх;
3.6. Сэжигтэй тохиолдол илэрсэн тухай мэдээг "Коронавируст халдвар (COVID-19)-ын тандалт, сэргийлэлтийн түр заавар"-т тусгасан бүртгэл, мэдээллийн дагуу мэдээлэх;

**Дөрөв. Ойрын хавьталд авах хариу арга хэмжээ**

4.1. Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдолд хавьтлын судалгааг хийж, ойрын хавьтлыг тогтоох;
4.2. Ойрын хавьтлыг эмчийн хяналтан дор 14-21 хоногийн турш ажиглах;
4.3. Сэжигтэй, магадлалтай тохиолдлын онош үгүйсгэгдсэн үед ойрын хавьтлын хяналтыг зогсоох;
4.4. Ойрын хавьтлыг өрх, сум, тосгоны эмчийн хяналтад гэрийн нөхцөлд тусгаарлахдаа дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

4.4.1. Гэр бүлийн бусад гишүүдээс тусдаа 1 өрөөнд өөрийгөө тусгаарлах боломжтой байх;
4.4.2. Цөөн ам бүлтэй байх;
4.4.3. Нийтийн байр, оюутны байранд амьдардаггүй байх;
4.4.4. Гэр бүлийн гишүүд дотор ахмад настай, архаг суурь өвчтэй, нярай, бага насны хүүхэд байхгүй байх;

4.5. Ойрын хавьталд шинж тэмдгийн тандалтыг өдөр бүр хийж, халууныг өдөрт 2 удаа үзэж, тэмдэглэл хөтлөх;
4.6. Хяналтын хугацаанд гэрээсээ гарахгүй, зочин урихгүй, олон хүнтэй уулзахгүй байхыг анхааруулах;
4.4. Батлагдсан тохиолдолд тусгаарлагдан ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндэд тавих хяналт:

4.4.1. Эрүүл мэндийн ажилтан 14 хоног тусгаарлагдан ажиллана.

4.4.2. Батлагдсан тохиолдолд тусламж, үйлчилгээ үзүүлсэн сүүлийн өдрөөс эхлэн ажиглалтын байранд үргэлжлүүлэн 14 хоног хянана.

4.4.3. Эрүүл мэндийн ажилтны биеийн халууныг өдөрт 2 удаа үзэж, өдөр бүр шинж тэмдгийн тандалт хийнэ.

4.4.4. Тусгаарлагдан ажиллах эхний өдөр цээжний рентген зураг авахуулна.

4.4.5. Ажиглалтын байрнаас гарахын өмнө цээжний рентген зураг дахин авч, хамар, залгиураас сорьц авч, шинжилнэ.

4.5. Батлагдсан тохиолдолд тусламж үзүүлэх эрүүл мэндийн ажилтны ар гэрийн нөхцөл байдлыг судалж сонгоно.

4.6. Цусны даралт ихэсдэг, зүрх, судасны архаг өвчин, чихрийн шижин, хавдартай, амьсгалын замын архаг эмгэгтэй эрүүл мэндийн ажилтныг батлагдсан тохиолдолд тусламж үзүүлэхээр томилон ажиллуулахыг хориглоно.

4.7. Тусгаарлагдан ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтны халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, хамгаалах хувцас, хэрэгслийг зөв өмсч, аюулгүй тайлж байгаа байдалд багийн ахлагч хяналт тавина. Эсвэл хянах хүнийг томилон ажиллуулж болно.

**Тав. Өрхийн эрүүл мэндийн төв, амбулатори, клиникт**

5.1. Халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг үзэх өрөөг тусад нь зохион байгуулсан байна.

5.2. Хөтөч ажилтанг ажиллуулж, халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийг үзлэгийн өрөө рүү чиглүүлэн, бусад үйлчлүүлэгчтэй хавьтал болохоос сэргийлнэ.

5.3. Үйлчлүүлэгчдэд амны хаалт зүүх, гарын эрүүл ахуй сахих, зөв ханиаж, найтаах санамж, анхааруулгыг өгнө.

5.4. Үзлэгийн өрөө бүрт амны хаалт, гар халдваргүйжүүлэх бодис байрлуулсан байна. Үзлэг, оношилгооны явцад халдварын сэжигтэй тохиолдол илэрвэл үйлчлүүлэгчид амны хаалт зүүлгэж, өрөөнөөс гаргахгүй, өрөөнд нэмж хүн оруулахгүй ба яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэхээс бусад тохиолдолд 1 метрээс дотогш зайд ойртохгүй байна.

5.5. Халдварын сэжигтэй тохиолдлыг мэдээллийн дагуу холбогдох ажилтанд утсаар мэдээлж, тусгаарлах эмнэлэгт шилжүүлнэ.

5.6. Эрүүл мэндийн ажилтан тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ амны хаалт, бээлийг тогтмол хэрэглэнэ.

5.7. Үйлчлүүлэгчийг шилжүүлсний дараа эмнэлэгт эцсийн халдваргүйжүүлэлт хийнэ.

**Зургаа. Яаралтай тусламжийн дуудлага болон гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх үед**

6.1. Халдварын сэжигтэй тохиолдлын дуудлага хүлээн авсан ажилтан нь дуудлагаар очих эмчид урьдчилан мэдэгдэнэ. Дуудлаганд очиж ажиллах эрүүл мэндийн ажилтан хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөнө.

6.2. Дуудлагаар очсон эмч халдварыг сэжиглэсэн тохиолдолд тусгаарлах эмнэлэгт урьдчилан мэдэгдэж, үйлчлүүлэгчид амны хаалт зүүлгэн, эмнэлгийн машинаар хүргэж өгнө.

6.3. Гэрт болон тээвэрлэсэн тээврийн хэрэгсэлд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг холбогдох байгууллага хийнэ.

**Долоо. Коронавируст халдвараас бусад тохиолдолд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлэг**

7.1. Үйлчлүүлэгчид болон эрүүл мэндийн ажилтны дунд коронавируст халдварын шинж тэмдгийн тандалтыг өдөр бүр хийнэ.

7.2. Амьсгалын замын халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгч илэрсэн тохиолдолд тусгаарлаж эмчилнэ.

7.3. Коронавируст халдварын сэжигтэй тохиолдол илэрвэл тусгаарлах өрөөнд шилжүүлэн, мэдээлж, тусгаарлах эмнэлэг рүү эмнэлгийн зориулалтын машинаар тээвэрлэнэ.

7.4. Эрүүл мэндийн ажилтан амны хаалт тогтмол хэрэглэж, гарын эрүүл ахуйг сайтар сахина.

7.5. Халдварын сэжигтэй, батлагдсан тохиолдлыг шилжүүлэх боломжгүй, нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд тухайн эмнэлгийн тусгаарлах өрөөнд тусгаарлаж эмчилнэ.

7.6. Нэг өрөөнд хамт байсан үйлчлүүлэгч болон бусад ойрын хавьтлуудыг бүртгэж, ажиглалтад авна.

**Найм. Хавьтлын менежмент**

8.1. Батлагдсан тохиолдолд тархвар судалгаа хийж, ойрын хавьтлыг хяналтанд авна.

8.2. Ойрын хавьтлыг батлагдсан тохиолдолтой хамгийн сүүлд хавьтал болсноос хойш 14-21 хоног ажиглалтын байранд хянана.

8.3. Сэжигтэй тохиолдол онош үгүйсгэгдсэн үед ойрын хавьтлын хяналтыг зогсооно.

8.4. Ойрын хавьталд халдварын шинж тэмдгийн тандалтыг өдөр бүр хийж, халууныг өдөрт 2 удаа үзэж, тэмдэглэл хөтлөнө.

8.5. Гэр бүлийн бусад гишүүдээс тусдаа нэг өрөөнд өөрийгөө тусгаарлах боломжтой, ам бүл цөөн, нийтийн байр, оюутны байранд амьдардаггүй, гэр бүлийн гишүүд дотор ахмад настай, архаг суурь өвчтэй, нярай хүүхэд байхгүй зэрэг нөхцлийг харгалзан ойрын хавьтлыг өрхийн эмчийн хяналтанд гэрт нь тусгаарлаж болно.

8.6. Гэрээр тусгаарлаж байгаа үед хяналтын хугацаанд гэрээс гарахгүй, зочин урихгүй, олон хүнтэй хавьтал болохгүй байх ба эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд харьяалах эрүүл мэндийн байгууллагад утсаар яаралтай мэдэгдэхийг зөвлөнө.

8.7. Ойрын хавьталд эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд "сэжигтэй тохиолдол" гэж үзээд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**Ес. Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл хэрэглэх заавар**

9.1. Хамгаалах хувцас, хэрэгсэл нь шингэн нэвчихгүй, чөлөөтэй хөдлөх боломжтой, биеийн хэмжээнд тохирсон байна.

9.2. Хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөх, тайлах хэсэгт зөв өмссөн эсэхийг хянах зорилгоор биеийг бүхлээр нь харах боломжтой том хэмжээтэй толь байрлуулсан байна.

9.3. Өмсөх, тайлах аргачлал, дараалал бүхий зурагт хуудас байршуулсан байна.

9.4. Хамгаалах хувцас, хэрэгслийг зүй зохистой хэрэглэхэд дараах зарчмыг баримтална.

9.4.1. Тусламж, үйлчилгээг нэг дор үзүүлж, эрүүл мэндийн ажилтны орох давтамжийг багасгана.

9.4.2. Ижил оношоор тусгаарлагдсан бүх үйлчлүүлэгчдэд нэг хамгаалах хувцастайгаа тусламж, үйлчилгээ үзүүлж дуусгана. Үйлчлүүлэгч болон өрөө хооронд хамгаалах хувцсыг дахин солих шаардлагагүй.

9.4.3. Үйлчлүүлэгчид хүрсэн бол дараагийн үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэхийн өмнө гадна бээлийг солино.

9.5. Хамгаалах хувцас илт бохирдоогүй, урагдаж цоороогүй бол тасралтгүй 4 цаг хүртэл хугацаагаар хэрэглэж болно.

Хүснэгт 4. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед хэвтэн эмчлүүлэх хэсэгт хэрэглэгдэх хамгаалах хувцас, хэрэгсэл

| Хаана | Эрүүл мэндийн ажилтан болон өвчтөн | Хийх үйл ажиллагаа | Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ажилбар |
|---|---|---|---|
| Өвчтний өрөө | Эрүүл мэндийн ажилтан | Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөн тэй шууд харьцах | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Малгай<br>4. Бээлий<br>5. Нүдний шил |
| | | Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнд аэрозол үүсгэх ажилбар хийх | 1. Шүүлтүүртэй амны хаалт (N95 эсвэл FFP2)<br>2. Комбинзон<br>3. Халад<br>4. Малгай<br>5. Бээлий<br>6. Нүдний шил |
| | Асрагч, үйлчлэгч | Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтний өрөөнд орох | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Малгай<br>4. Цэвэрлэгээний зузаан бээлий<br>5. Нүдний шил (органик материал болон химийн бодис үсрэх эрсдэлийн үед)<br>6. Түрийтэй эсвэл ажлын битүү гутал |
| Өвчтөн дам жин өнгөрсөн бусад хэсэгт (тасаг, коридор) | Эрүүл мэндийн болон бусад хүн | Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөн тэй харьцахаас бусад үйл ажиллагаа | Амны хаалт |
| Хүлээн авах хэсэг /эрэмбэ лэн ангилах/ | Эрүүл мэндийн ажилтан | Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөн тэй шууд хүрэлцэхгүй зайнаас халуун үзэх, асуумж авах | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Бээлий<br>3. Халад<br>4. Малгай |
| | Амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн хүн | Тусгаарлах өрөөнд зайнаас халуун үзэх, асуумж авах, | Нэг метрээс дээш зай барьж ажиллах<br>1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Бээлий<br>3. Халад |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 4. Малгай |
| | Амьсгалын замын өвчнөөс бусад шинж тэмдэг илэрсэн | Зөвлөгөө өгч шаардагдах арга хэмжээг авах | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Бээлий<br>3. Халад<br>4. Малгай |
| Лабораторид | Лаборант | Амьсгалын замын эрхтнээс сорьц авах | 1. Шүүлтүүртэй амны хаалт (N95 эсвэл FFP2)<br>2. Комбинзон/<br>3. Халад<br>4. Бээлий<br>5. Нүдний шил |
| Захиргааны хэсэгт | Эмнэлгийн болон бусад хүн | Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнтэй харьцахаас бусад ажил үүрэг | Амны хаалт |

Хүснэгт 5. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед амбулаторид хэрэглэгдэх хамгаалах хувцас, хэрэгсэл

| Хаана | Эрүүл мэндийн ажилтан болон өвчтөн | Хийх үйл ажиллагаа | Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ажилбар |
|---|---|---|---|
| Үзлэгийн өрөө | Эрүүл мэндийн ажилтан | Амьсгалын замын өвчний шинж тэмдэгтэй өвчтөнд эмнэлгийн үзлэг хийх | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Малгай<br>4. Бээлий<br>5. Нүдний шил |
| | | Амьсгалын замын өвчний шинж тэмдэггүй өвчтөнд эмнэлгийн үзлэг хийх | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Малгай<br>4. Бээлий |
| | Амбулаториор үйлчлүүлэгч | Бүх нөхцөлд | Амны хаалт |
| | Асрагч, үйлчлэгч | Амьсгалын замын өвчний хам шинжтэй өвчтний үзлэгийн дараа цэвэрлэгээ хийх | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Малгай<br>4. Зузаан бээлий<br>5. Нүдний шил (органик материал болон химийн бодис үсрэх эрсдлийн үед)<br>6. Түрийтэй гутал эсвэл ажлын битүү шаахай |
| Хүлээлгийн танхимд үйлчлүүлэгчдийг хоёр ангилан нэг метрээс доошгүй зайнд суулгана. | Амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгч | Өвчтөнийг тусгаарлах өрөөнд оруулах | Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт |
| | Амьсгалын замын шинж тэмдэггүй үйлчлүүлэгч | | Амны хаалт |
| Захиргааны хэсэг | Эмнэлгийн болон бусад хүн | Бусад ажил хэрэг | Амны хаалт |
| Угтах хэсэг/эрэмбэлэн ангилах/ | Эрүүл мэндийн ажилтан | Зайнаас халуун үзэх, асуумж авах | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Бээлий<br>3. Халад<br>4. Малгай |

| | | | |
|---|---|---|---|
| | Амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн хүн | Тусгаарлах өрөөнд зайнаас халуун үзэх, асуумж авах, | Нэг метрээс доошгүй зайнаас ажиллах<br>1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Бээлий<br>3. Халад<br>4. Малгай |
| | Амьсгалын за мын өвчнөөс бусад шинж тэмдэг илэрсэн | Зөвлөгөө өгч шаардагдах арга хэмжээг авах | 1. Амны хаалт<br>2. Бээлий<br>3. Халад<br>4. Малгай |

Хүснэгт 6. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед шуурхай хариу арга хэмжээний багийн гишүүдийн хэрэглэх хамгаалах хувцас, хэрэгсэл

| **Хаана** | **Эрүүл мэндийн ажилтан болон өвчтөн** | **Хийх үйл ажиллагаа** | **Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ажилбар** |
|---|---|---|---|
| Бүх газарт | Багийн гишүүд | Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдол, түүний хавьтлуудтай ярилцлага хийх, асуумж авах | Алсын зайн буюу гар утас, видео дуудлага ашиглах |
| | | Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй болон батлагдсан хүнээс биечлэн асуумж судалгаа авах | Нэг метрээс доошгүй зайд харьцах<br>1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Бээлий<br>3. Малгай<br>4. Халад |
| | | Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтний шинж тэмдэггүй ойрын хавьтлаас биечлэн асуумж судалгаа авах | Нэг метрээс доошгүй зайд харьцах, асуумжийг гэрийн эсвэл хаалганы гаднаас авах, гэрийн эд зүйлд хүрэхгүй байх, зайнаас халуун хэмжих<br>1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Бээлий |

Хүснэгт 7. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед хилийн нэвтрэх цэгт хэрэглэгдэх хамгаалах хувцас, хэрэгсэл

| Хаана | Эрүүл мэндийн ажилтан болон өвчтөн | Хийх үйл ажиллагаа | Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ажилбар |
|---|---|---|---|
| Захиргааны хэсэгт | Бүх ажилтан | Бүх тохиолдолд | Амны хаалт |
| Хяналтын хэсэг | Ажилтан /Онгоц, галт тэрэг, автомашин/ | Эрүүл мэндийн асуумж авах, зайнаас халуун хэмжих | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Малгай<br>4. Бээлий<br>5. Нүдний шил |
| | Ажилтан /паспорт, тасалбар шалгагч/ | Паспорт тамгалах, шалгах, тасалбар шалгах | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Бээлий<br>3. Нүдний шил |
| | Ажилтан /Тусгаарлах өрөө/ | Амьсгалын замын өвчний шинж тэмдэгтэй зорчигчоос аяллын түүхийн асуумж авах | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Бээлий<br>3. Халад |
| | Үйлчилгээний ажилтан | Түр тусгаарлах өрөө цэвэрлэх | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Цэвэрлэгээний зузаан бээлий<br>4. Нүдний шил (органик материал болон химийн бодис үсрэх эрсдлийн үед)<br>5. Түрийтэй гутал эсвэл ажлын битүү шаахай |
| | Ачигч, ачаа тээврийн ажилтан | Коронавируст халдвар (COVID-19) бүртгэгдсэн улс орнуудаас зөөвөрлөгдөн ирсэн ачаа тээштэй харьцах үед | 1. Бээлий**<br>2. Амны хаалт<br>3. Ажлын хувцас |
| Түргэний машин болон бусад тээврийн хэрэгсэл | Эрүүл мэндийн ажилтан | Сэжигтэй өвчтнийг эмнэлэг рүү тээвэрлэх | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Бээлий<br>4. Нүдний шил |
| | Жолооч | Сэжигтэй өвчтнийг тээвэрлэх, туслах үед | |
| | Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй өвчтөн | Тээвэрлэх үед | |
| | Жолооч, үйлчилгээний ажилтан | Сэжигтэй өвчтнийг тээвэрлэсний дараа цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Цэвэрлэгээний зузаан бээлий<br>4. Нүдний шил (органик материал болон химийн бодис үсрэх эрсдэлтэй үед)<br>5. Түрийтэй битүү гутал |

Хүснэгт 8. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед ажиглалтын байранд хэрэглэгдэх хамгаалах хувцас, хэрэгсэл

| **Хаана** | **Эрүүл мэндийн ажилтан болон өвчтөн** | **Хийх үйл ажиллагаа** | **Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ажилбар** |
|---|---|---|---|
| Өрөөнд | Иргэн | Ажилтантай харьцах бүх тохиолдолд | Амны хаалт |
| Ажиглалтын байранд | Цагдаа, онцгой байдлын ажилтан | Ажиглалтад байгаа иргэнтэй нэг метрээс дотогш зайд харьцах үед | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Бээлий**<br>4. Нүдний шил<br>5. Малгай |
| | | Бусад тохиолдолд | Нэг метрээс доошгүй зайд харьцах<br>1. Амны хаалт |
| Ажиглалтын өрөөнд | Эрүүл мэндийн ажилтан | Зайнаас халуун хэмжих, асуумж авах | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Бээлий<br>3. Халад<br>4. Малгай |
| | | Коронавируст халдвар (COVID-19)-ын шинж тэмдэг бүхий өвчтөнөөс биечлэн асуумж судалгаа авах | Нэг метрээс доошгүй зайд харьцах, асуумжийг хаалганы гаднаас авах, зайнаас халуун хэмжих<br>1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Бээлий<br>3. Халад |
| Ажиглалтын өрөө, байранд | Үйлчилгээний ажилтан | Өрөө цэвэрлэх | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Цэвэрлэгээний зузаан бээлий<br>4. Нүдний шил (органик материал болон химийн бодис үсрэх эрсдэлийн үед)<br>5. Түрийтэй гутал эсвэл ажлын битүү шаахай |
| Хоол үйлдвэрлэл | Тогооч, бэлтгэгч | Хоолны сав, хэрэгслийг хүлээн авах, цэвэрлэх | 1. Амны хаалт<br>2. Хормогч<br>3. Ахуйн бээлий<br>4. Нүдний шил (органик материал болон химийн бодис үсрэх эрсдлийн үед) |
| | | Бусад тохиолдолд | Амны хаалт |
| Харуулын байр | Харуул хамгаалалт | Бүх тохиолдолд | Нэг метрээс доошгүй зайд харьцах<br>Амны хаалт |
| Захиргаа, бусад хэсэгт | Зохион байгуулагч ханган нийлүүлэгч, галч | Бүх тохиолдолд | Амны хаалт |

Хүснэгт 9. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед эмнэлгээс бусад орчинд хэрэглэгдэх хамгаалах хувцас, хэрэгсэл

| Хаана | Хэн | Хийх үйл ажиллагаа | Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл |
|---|---|---|---|
| **Тээврийн хэрэгсэлд:** | | | |
| Нийтийн тээврийн автобус, такси | Жолооч | Бүх тохиолдолд | Амны хаалт |
| | Зорчигч | Бүх тохиолдолд | Амны хаалт |
| Галт тэрэг | Машинист | Бүх тохиолдолд | Амны хаалт |
| | Үйлчлэгч, билет шалгагч | Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй тохиолдолтой харьцах | Нэг метрээс доошгүй зайд харьцах<br>1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Бээлий<br>3. Нүдний шил |
| | | Бусад тохиолдолд | 1. Амны хаалт<br>2. Бээлий** |
| Агаарын хөлөг | Нисгэгч | Бүх тохиолдолд | Амны хаалт |
| | Үйлчлэгч | Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй тохиолдолтой харьцах | Нэг метрээс доошгүй зайд харьцах<br>4. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>5. Бээлий<br>6. Нүдний шил |
| | | Бусад тохиолдолд | 1. Амны хаалт<br>2. Бээлий** |
| **Бусад үйлчилгээний байгууллагад:** | | | |
| Худалдаа үйлчилгээний төвүүд, эмийн сан, банк, нэг цэгийн үйлчилгээ, нотариат, үсчин, гоо сайхан гэх мэт | Бүх ажилчид | Бусад тохиолдолд | Амны хаалт |
| | Үйлчлэгч, цэвэрлэгч | Цэвэрлэгээ хийх үед | 1. Ажлын хувцас<br>2. Амны хаалт<br>3. Цэвэрлэгээний зузаан бээлий<br>4. Нүдний шил (органик материал болон химийн бодис үсрэх эрсдлийн үед)<br>5. Ажлын битүү гутал |
| | | Бусад тохиолдолд | Амны хаалт |
| Олон нийтийн газар (сургууль, дэлгүүр, галт тэрэгний буудал гэх мэт) | Амьсгалын замын өвчний шинж тэмдэггүй хүн | Бүх тохиолдолд | Амны хаалт |
| Асрамж, халамжийн газар | Эрүүл мэндийн ажилтан | Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнтэй шууд харьцах, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Малгай<br>4. Бээлий<br>5. Нүдний шил |
| | | Коронавируст халдвар (COVID-19)-ын шинж тэмдэггүй өвчтөнтэй шууд харьцах, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Малгай<br>4. Бээлий |
| | Бүх ажилчид | Бүх тохиолдолд | Амны хаалт |
| Гэрийн нөхцөлд | Амьсгалын замын өвчний шинж тэмдэгтэй хүн | Өөрийгөө тусгаарлах, утсаар зөвлөгөө авах | Гэр бүлийн бусад гишүүдээс нэг метрээс доошгүй зайтай байх<br>1. Амны хаалт |

| | | | |
|---|---|---|---|
| | Гэр бүлийн гишүүд | Зайнаас харьцах | Амны хаалт |
| | Өвчтнийг гэрээр асарч байгаа хүн | Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтний ялгадас, өтгөн шингэнийг цэвэрлэх | 1. Бээлий<br>2. Амны хаалт<br>3. Хормогч (шингэн үсрэх эрсдэлийн үед)<br>4. Малгай<br>5. Нүдний шил |
| | Эрүүл мэндийн ажилтан | Коронавируст халдвар (COVID-19)-тай өвчтөнтэй шууд харьцах, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх | 1. Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт<br>2. Халад<br>3. Малгай<br>Бээлий<br>4. Нүдний шил |

***Тайлбар:*** *Амны хаалт - эмнэлгийн зориулалтын бус бусад амны хаалт, эмнэлгийн нэг удаагийн амны хаалт - мэс заслын амны хаалт, нүдний шил (нүдний шил эсвэл нүүрний хаалт), бээлий ** - эмнэлгийн зориулалтын бус бусад бээлий*

Эрүүл мэндийн сайдын 2020 оны
04...сарын 29...-ны өдрийн А/269 дугаар
тушаалын долоодугаар хавсралт

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ҮЕД ИРГЭНИЙГ ТУСГААРЛАХ, АЖИГЛАХ ТҮР ЗААВАР

## Нэг. Хилийн нэвтрэх цэгт хийх эрэмбэлэн ангилалт

### 1.1 Мэргэжлийн хяналтын байгууллагын үүрэг

1.1.1. Агаарын хилийн боомт дээр APIC цахим програмаар, галт тэрэгний дарга, автобус, автомашины жолоочоос зорчигчийн тоо, суудлын дугаар бүхий нэрсийн жагсаалтыг авч, эрэмбэлэн ангилалтын анхан шатны төлөвлөлтийг хийнэ.

1.1.2. Аяллын явцад болон хил нэвтрэхээс өмнө зорчигч бүрээс “Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг”-ийн хуудсаар асуумж авч, биеийн халууныг хэмжин, тандалт судалгаа хийж, зорчигчдыг ангилан тээврийн хэрэгслээс буулгах дэс дарааллыг төлөвлөн хэрэгжүүлнэ.

1.1.3. Сэжигтэй зорчигчийг бусад зорчигчдоос түр тусгаарлан, тээврийн хэрэгслээс түрүүлж буулган, хариу арга хэмжээний багт шилжүүлнэ.

1.1.4. Сэжигтэй зорчигчийг буулгасны дараа эрүүл мэндийн шалтгаантай зорчигчдыг буулгана.

1.1.5. Ойрын хавьтлыг тодорхойлж, шуурхай хариу арга хэмжээний багт, бусад зорчигчид болон нислэгийн баг, галт тэрэгний дарга, үйлчлэгч, жолооч, томилгооны ажилтныг ажиглалтад шилжүүлнэ.

### 1.2. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

1.2.1. Шуурхай хариу арга хэмжээний баг сэжигтэй болон ойрын хавьтлын биеийн халууныг давтан хэмжиж, эмнэлзүйн үзлэг, тандалт судалгааг хийн, сэжигтэй тохиолдол, ойрын хавьтлыг эрүүл мэндийн байгууллагад тээвэрлэн хүргэнэ.

1.2.2. Тусгаарлалт, ажиглалтад зорчигчдыг тээвэрлэн хүргэсний дараа тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлнэ.

### 1.3. Иргэнийг тусгаарлах, ажиглах байранд тээвэрлэн хүргэх

1.3.1. Сэжигтэй тохиолдол болон ойрын хавьтлыг хариу арга хэмжээний багийн хяналтан дор зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн, эрүүл мэндийн байгууллагад хүргэнэ.

1.3.2. Эрүүл мэндийн шалтгаантай зорчигчдыг сонгосон эмнэлэгт эмчийн хяналтан дор зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн хүргэнэ.

1.3.3. Онцгой байдлын байгууллага бусад зорчигчдыг урьдчилан бэлтгэсэн тусгаарлан ажиглах байранд тээвэрлэн хүргэнэ.

1.3.4. Цагдаагийн байгууллага зорчигчдыг тусгаарлах, ажиглах байранд хүргэх тээврийн хэрэгслийг хөтөч машинаар хамгаалан хүргэнэ.

1.3.5. Шуурхай хариу арга хэмжээний баг сэжигтэй тохиолдол, ойрын хавьтлыг эрүүл мэндийн байгууллагад хүлээлгэн өгнө.

1.3.6. Онцгой байдлын байгууллагын алба хаагч бусад зорчигчдыг ажиглах байрны эмч, эмнэлгийн мэргэжилтэн, онцгой байдлын болон цагдаагийн байгууллагын алба хаагчдад хүлээлгэн өгнө.

**1.4. Иргэдийг ажиглах байранд байрлуулах**

1.4.1. Ажиглах байр нь иргэдийг хүлээн авахын өмнө тэдгээрийн мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллагаас урьдчилан авч, бэлэн байдлыг хангана.

1.4.2. Ажиглах байранд иргэдийг нэг өрөөнд "Нэг хүн", "Нэг гэр бүл", "Иргэн ба асран хамгаалагч" гэсэн зарчмыг баримтлан эмчийн хяналтад 21 хоног тусгаарлан ажиглана.

1.4.3. Коронавируст халдвар (COVID-19)-аар өвчлөөд эдгэрсэн хүнийг ажиглалтын байранд 14 хоног, үргэлжлүүлэн гэрийн ажиглалтад 14 хоног байлгана.

1.4.4. Байрны эд хогшлыг иргэнд жагсаалтын дагуу хүлээлгэн өгч, холбогдох журмыг танилцуулж, гарын үсэг зуруулна.

1.4.5. Иргэд хурц үзүүртэй мэс, архи, согтууруулах ундаа, мансууруулах сэтгэцэд нөлөөлөх, халуун бууруулах, өвчин намдаах эм, бодис, түргэн гэмтэж, муудах хүнсний бүтээгдэхүүн авч орохыг хориглоно.

1.4.6. Иргэдийг өрөөнд байрлуулсаны дараа өрөөний хаалганы гадна тал, шат, цахилгаан шат, хүлээлгийн танхим, гадна хаалга, үүдний хэсгүүдэд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тухайн байгууллага тогтмол хийнэ.

**1.5. Ажиглах байранд тавигдах шаардлага**

1.5.1. Ажиглах байрыг эмнэлэг, сувилал, амралтын газар, зочид буудал, их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр, спорт цогцолбор, заал, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, цэцэрлэг гэсэн дэс дараалаар сонгоно.

1.5.2. Ажиглах байр нь цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны системд холбогдсон, галын аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлд тавигдах шаардлагыг хангасан байна.

1.5.3. Ундны усны төвлөрсөн системд холбогдоогүй бол харъяалах нутаг дэвсгэр дэх мэргэжлийн хяналтын байгууллагаар ундны усны дээжид нян судлалын шинжилгээг хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна.

1.5.4. Төвлөрсөн бус усан хангамжтай ажиглах байрны усны эх булаг, ус түгээгүүрийн шугам сүлжээ, ус нөөцлөх сан, шахуургын станц, ус түгээх байранд холбогдох журмын дагуу хамгаалалтын бүс тогтоож, бохирдолтоос хамгаалах арга хэмжээг авч, аюулгүй байдлыг хангасан байна.

1.5.5. Худаг болон ус түгээх байрны ус нөөцлөх савыг 3 сар тутам, ус зөөвөрлөх хадгалах савыг долоо хоногт 2-оос доошгүй удаа угааж цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

1.5.6. Ус хангамжийн эх үүсвэрийн худаг болон ус түгээх байранд өдөрт 2-оос доошгүй удаа халдваргүйжүүлэх бодистой чийгтэй цэвэрлэгээ хийх, ус түгээх хоолойг бохирдлоос хамгаалан өлгүүр, хошуувчтай байлгах, ус түгээх хоолойн амсар болон хүний гар хүрдэг хэсгийн гадаргууг тогтмол халдваргүйжүүлэх арга хэмжээг авч, 0.02%-ийн клорсепт-17, 0.25%-ийн гипохлорт натри, 0.015%-ийн жавелион, 0.25%-ийн кальцийн гипохлоридын уусмалаас сонгож хэрэглэнэ.

1.5.7. Ажиглах байрны цонхны салхивчийг нээх боломжтой, насанд хүрээгүй иргэдийн аюулгүй байдлыг хангасан байна.

1.5.8. Ажиглах байрны өрөө бүр ариун цэврийн өрөө, гар угаах нөхцөлөөр хангагдсан, нэг өрөөнд гэр бүл, асран хамгаалагчийг хамт байрлуулсан тохиолдолд ор хоорондын зайг нэг метрээс доошгүй байхаар зохион байгуулна.

1.5.9. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, цэвэрлэгээний ажилтны байрлах өрөө нь гар угаах, усанд орох нөхцөлөөр хангагдсан эсвэл гар угаах, усанд орох хэсэг нь ажиглалтад байгаа иргэдээс тусдаа байхаар зохион байгуулагдсан байна.

1.5.10. Сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах өрөөг бэлтгэсэн байна.

1.5.11. Шаардлагатай үед хэрэглэх анхны болон яаралтай тусламжийн эм, хэрэгслийг бэлтгэнэ.

1.5.12. Сэжигтэй тохиолдол илэрсэн үед хэрэглэх иж бүрэн хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл (комбинзон, N95 амны хаалт, нүдний шил, нүүрний хаалт, бээлий, малгай зэрэг)-ийн нөөцийг бэлтгэсэн байна.

1.5.13. Ажиглалтад байгаа иргэдийг чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хоол хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.5.14. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад алба хаагчийн байрлах өрөө, хамгаалах хувцас, хэрэгслийг тайлах хэсэг, гал тогооноос ажиглах өрөөнд хоол зөөвөрлөх, хоолны хэрэгслийг гал тогоонд хүргэх болон хог хаягдлыг зөөвөрлөх чиглэл зэрэг орох, гарахыг хориглосон байршлуудад анхааруулах тэмдэглэгээг хийсэн байна.

1.5.15. Өрөө бүрт ариун цэврийн цаас, гарын болон эдийн саван, аяга, таваг угаагч шингэн, порлон, гал тогооны алчуур, тавилга хэрэгсэл арчих тоосны болон шалны алчуур, ариун цэврийн өрөөнд хэрэглэх угаалга, цэвэрлэгээний бодис, хогийн сав, хар өнгийн хогийн уут зэргийг бэлтгэн байршуулсан байна.

1.5.16. Өрөө бүрт иргэд эрүүл мэндийн байдлаа хянах "Ажиглалтын хуудас", халуун хэмжигч (эмнэлгийн ажилтан халуун хэмжихээр зохицуулсан бол шаардлагагүй), эмч, эмнэлгийн мэргэжилтэн, буудлын зохион байгуулагчтай холбоо барих утасны жагсаалт, ажиглалтын үед мөрдөх санамж, анхааруулга, өрөөнд хориглох зүйлсийн зөвлөмж, хоолны цагийн хуваарь, өрөөнөөс хог гаргах цагийн хуваарь зэргийг байршуулсан байна.

1.5.17. Өрөө бүрийн хаалганы гадна хоол түгээхэд хэрэглэх, сандал, ширээ, шүүгээ зэргийн аль нэгийг байрлуулна.

1.5.18. Иргэн өрөөний өдөр тутмын цэвэрлэгээг өөрсдөө гүйцэтгэх санамжийг байрлуулна.

1.5.19. Тусгаарлан ажиглах байранд үйлчилгээ үзүүлж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, алба хаагчдаас бусад хүн орох, иргэний хэрэглэсэн эд зүйлсийг гадагш гаргахыг хориглож, цагдаагийн байгууллагын хамгаалалтад байлгана.

1.5.20. Аюултай хог хаягдлыг нийслэлд "Элемент" ХХК-тай, энгийн хог хаягдлыг зайлуулах талаар тухайн орон нутгийн тохижилт, үйлчилгээний компанитай гэрээ хийсэн байна.

**1.6. Ажиглах байрны удирдлагын үүрэг**

1.6.1. Хувь хүний нууц, эрүүл мэндийн байгууллагын талаарх мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас бусдад задруулахыг хориглоно.

1.6.2. Ажиглах байранд байгаа иргэд, ажиллагсдын хоол, хүнсний нийлүүлэлт, тээвэрлэлт, хадгалалт, үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналт тавьж, чанартай, аюулгүй хоол, хүнсээр хангана.

1.6.3. Улсын бүртгэлд бүртгэгдсэн, хаяг шошгоны зөрчилгүй, хэрэглэх заавар тодорхой халдваргүйжүүлэх бодисыг нийлүүлж, батлагдсан зааврын дагуу хэрэглэж байгаа эсэхэд дотоодын хяналт тавьж ажиллана.

1.6.4. Эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан угаалга, цэвэрлэгээг тогтмол хийж, хог хаягдлыг тогтмол зайлуулна.

1.6.5. Ажиглалтын хугацаанд байрлаж ажиллах ажилтнуудын хувийн бэлтгэлийг бүрэн хангуулна.

1.6.6. Иргэдийг хүлээж авах өрөөнүүдийн давхар, хаалганы дугаар, орны тоотой бүртгэлийг гаргасан байна.

1.6.7. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, цэвэрлэгээний ажилтан, тогооч болон бусад ажилтныг халдвараас сэргийлэх сургалтанд бүрэн хамруулсан байна.

1.6.8. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй харьцах, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцох тогооч, ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулсан байна.

1.6.9. Эмч, эмнэлгийн мэргэжилтний хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг харьяа эрүүл мэндийн байгууллага, цэвэрлэгээний ажилтны хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг тухайн байгууллага тус тус хариуцан хангана.

1.6.10.Ажиглалтын хугацаанд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, цэвэрлэгээний ажилтанг ээлж солихгүйгээр ажиллуулна.

**1.7. Эмч, эмнэлгийн мэргэжилтний үүрэг**

1.7.1. Ажил үүрэг гүйцэтгэхтэй холбоотой хууль, тогтоомж, тушаал, заавар, журмыг хэрэгжүүлж ажиллана.

1.7.2. Өрөө бүрт биеийн халуун хэмжигч байгаа тохиолдолд ажиглалтанд байгаа иргэнээр биеийн халууныг өдөрт 2-оос доошгүй удаа хэмжүүлж, тэмдэглэл хөтлөн, эрүүл мэндийн байдалд өдөр бүр хяналт тавина.

1.7.3. Өрөө бүрт биеийн халуун хэмжигч байхгүй тохиолдолд эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиглалтад байгаа иргэдийн биеийн халууныг өдөрт 2-оос доошгүй удаа зайнаас хэмжиж, тэмдэглэл хөтлөн, эрүүл мэндийн байдалд нь хяналт тавина.

1.7.4. Ажиглалтад байгаа иргэнд халуурах болон бусад шинж тэмдэг илэрсэн үед утсаар нэн даруй мэдэгдэхийг анхааруулна.

1.7.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон цэвэрлэгээний ажилтантай харьцах үедээ амны хаалт зүүхийг иргэнд зөвлөнө.

1.7.6. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн өөрсдийн болон бусад үйлчилгээний ажилтнуудын эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, биеийн халууныг өдөр бүр хэмжиж, тэмдэглэл хөтлөнө.

1.7.7. Ажиглалтад байгаа иргэдийн өрөөнд зайлшгүй шаардлагаар орж, гарч байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилтны талаарх мэдээллийг тухай бүр бүртгэж, тэмдэглэл хөтөлнө.

1.7.8. Хоол түгээх, биеийн халуун хэмжих, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үед нэг удаагийн халад, малгай, эмнэлгийн амны хаалт, үзлэгийн бээлий өмсөнө.

1.7.9. Халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед иж бүрэн хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг өмсч, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

1.7.10. Иргэнд ямар нэгэн зовиур, эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн үед үзлэг хийж, коронавируст халдварын сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

1.7.11. Хэрэв иргэнд эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай бол ажиглах байрны эмч нь холбогдох журам, зааврын дагуу харьяалах эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэж, тусламж, үйлчилгээнд хамруулах асуудлыг зохион байгуулна.

1.7.12. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь тусламж, үйлчилгээ үзүүлсний дараа хамгаалах хувцас, хэрэгслийг тайлахгүйгээр өөрийн амрах байр болон бусад хэсгүүдэд зорчихыг хориглоно.

1.7.13. Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөхийн өмнө, тайлсны дараа, ариун цэврийн өрөөнд орсны дараа, хоол идэхийн өмнө гарын ариун цэврийг чанд сахина.

1.7.14. Ажиглах байранд мөрдөгдөх халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

1.7.15. Ажиглах байранд байгаа иргэд, ажилтнуудад коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын сэргийлэлт, хяналтыг дагаж мөрдөх талаар зөвлөмж, зөвлөгөөг өгч ажиллана.

1.7.16. Иргэд үүрэг гүйцэтгэж буй ажилтан, албан хаагчдыг доромжлох, заналхийлэх, биед нь халдах аливаа үйлдэл гаргасан тохиолдолд цагдаагийн ажилтанд мэдэгдэнэ.

1.7.17. Гал тогооноос иргэдийн хоол, цайг хүлээн авч, ажиглалтын өрөөний үүдэнд байрлуулсан ширээн дээрх аяга,тавганд хийж түгээнэ.

1.7.18. Хоол түгээж дууссаны дараа хоолны сав, хэрэгслийг гал тогооны бохир хүлээн авах хэсэгт хүргэнэ.

1.7.19. Ажиглалтад байгаа иргэн бөөлжсөн, суулгасан зэрэг тохиолдолд цэвэрлэгээний ажилтанд тухай бүр мэдэгдэж, өрөөг цэвэрлүүлж, халдваргүйжүүлнэ.

1.7.20. Ажиглах байрны эмч, эмнэлгийн мэргэжилтэн иргэний овог, нэр, нас, хүйс, аяллын товч түүх, холбоо барих утас, оршин суугаа гэрийн хаяг, тусгаарлалтад орсон огноо зэрэг мэдээллийг ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгжийн Google.sheet файлын “Нэмэлт мэдээлэл” талбарт 24 цагийн дотор байршуулна. Мөн иргэн шилжсэн, ажиглалтаас гарсан тохиолдолд мэдээллийг нэмж мэдээлнэ.

**1.8. Цэвэрлэгээний ажилтны үүрэг**

1.8.1. Халдваргүйжүүлэх бодисыг найруулах арга, хэрэглээний талаарх сургалтад хамрагдсан байна.

1.8.2. Ажиглалтад байгаа иргэн шал болон бусад гадаргуу дээр бөөлжсөн, суулгасан тохиолдолд бохирдсон гадаргууг 30 минут халдваргүйжүүлээд тухайн хэсгийг бүрэн бүрхэхээр нэг удаагийн цаасан алчуур дээр нь тавьж, шингэнийг шингээсний дараа цэвэрлэж, угаалгын бодистой халуун усаар угаана. Шалыг 0.015%, ариун цэврийн өрөөг 0.03%-ийн жавелионы уусмал эсвэл хлор агуулсан бусад бодисоор халдваргүйжүүлнэ.

1.8.3. Цэвэрлэгээ, үйлчилгээ хийх, хог хаягдал цуглуулах үедээ нэг удаагийн халад, малгай, нүдний шил эсвэл нүүрний хаалт, эмнэлгийн амны хаалт, ахуйн бээлий өмсөнө.

1.8.4. Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг тайлахгүйгээр өөрийн амрах байр болон бусад хэсгүүдэд зорчихыг хориглоно.

1.8.5. Хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөхийн өмнө, тайлсны дараа, ариун цэврийн өрөөнд орсны дараа, хоол идэхийн өмнө, цэвэрлэгээ, үйлчилгээ хийсний дараа гарын ариун цэврийг сахина.

1.8.6. Өдөр бүр тодорхой цагт өрөөний үүдэнд гаргасан хатуу хог хаягдлыг цуглуулж, хог хаягдлын цэгт хүргэнэ.

1.8.7. Цэвэрлэгээ, үйлчилгээний дараа хамгаалах хувцас, хэрэгслийг зааврын дагуу тайлж, шар өнгийн уутанд цуглуулна.

1.8.8. Ажиглах өрөөний хаалганы гадна талын бариул, хонх, коридорын шал, явган хүний болон цахилгаан шат зэрэг гар хүрэлцэх гадаргуу өдөр бүр цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

1.8.9. Цахилгаан шат, хаалганы дээд хэсэг, хүлээлгийн танхимын гар хүрэхгүй хэсгүүдийг шүршиж халдваргүйжүүлнэ.

**1.9. Гал тогооны ажилтны үүрэг**

1.9.1.Хоолны цэсийг жишиг цэсэд нийцүүлэн боловсруулж, байгууллагын удирдлагаар батлуулж, мөрдөнө.

1.9.2. Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрүүл ахуйн нөхцөл, шаардлага хангасан газарт явуулна.

1.9.3. Эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой, баталгаажилттай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хоол үйлдвэрлэлд ашиглана.

1.9.4. Хоолыг зориулалтын халуун баригч бүхий битүүмжлэлтэй саванд хийж, зөөвөрлөнө.

1.9.5. Бэлтгэсэн хоол, хүнсний цуврал бүрээс 150 гр-аас доошгүй дээжийг ариутгасан саванд авч, битүүмжлэн, шошголж, $4^0$С-ийн хэмд, 72 цагаас багагүй хугацаанд хадгалж, бүртгэл хөтөлнө.

1.9.6. Хоолны сав, хэрэгслийг 2%-ийн содын уусмал, зориулалтын угаагч бодисоор цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

1.9.7. Хоол зөөх тэргэнцэрийг 0.015%-ийн жавелион эсвэл хлор агуулсан бусад бодисоор халдваргүйжүүлнэ.

1.9.8. Өөрийн эрүүл мэндийн байдал болон биеийн халуунд өдөр бүр хяналт тавьж, эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эмчид яаралтай мэдээлнэ.

1.9.9. Эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй шууд харьцах, гал тогооноос бусад хэсэгт зорчихыг хориглоно.

**1.10. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүрэг**

1.10.1. Ажиглах байрны дотор талд хянах, хамгаалалтын үүргийг 24 цагаар гүйцэтгэнэ.

1.10.2. Шаардлагатай тохиолдолд нийтийн хэв журмыг сахиулах чиглэлээр цагдаагийн байгууллагатай хамтран ажиллана.

1.10.3. Ажиглах байрны галын аюулгүй байдал, аврах зам, гарцын тэмдэг, тэмдэглэгээ, хэвийн ажиллагаанд хяналт тавина.

1.10.4. Ажиглалтад байгаа иргэдэд ирсэн эргэлтийн эд зүйлсийг дундын бүсээс авч, эмч нарт хүлээлгэн өгнө.

**1.11. Цагдаагийн байгууллагын алба хаагчийн үүрэг**

1.11.1. Цагдаагийн ажилтан шаардлагатай тохиолдолд дуудлагаар ирсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын үнэмлэхийг шалгаж нэвтрүүлнэ.

1.11.2. Ажиглах байрны гадна орчинд хэв журам, дэглэмийг сахиулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавина.

1.11.3. Иргэдэд хууль ёсны шаардлага тавьж, биелэлтийг хангуулна.

1.11.4. Ажиглах байранд гарсан гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоож, хууль зөрчсөн иргэдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна.

1.11.5. Нөхцөл байдлын мэдээллийг ЦЕГ-ын "Шуурхай удирдлагын штаб"-т тухай бүр илтгэж, өгөгдсөн үүргийг хэрэгжүүлнэ.

1.11.6. "Шуурхай штаб"-аас гаргасан жагсаалтад заагдсан эд зүйлсийг шалгаж, дундын бүсэд байршуулна.

**1.12. Иргэний үүрэг**

1.12.1. Ажиглалтад байгаа иргэн өөрийнхөө эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, биеийн халууныг өдөрт 2-оос доошгүй удаа хэмжиж, ажиглалтын хуудсанд тэмдэглэнэ (Хүснэгт 10). Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эмч, эмнэлгийн мэргэжилтэнд утсаар шуурхай мэдээлнэ.

1.12.2. Өрөөний цонхны салхивчийг цаг тутамд 15 минут нээж, агааржуулалт хийнэ.

1.12.3. Зааврын дагуу гараа тогтмол угааж, гарын ариун цэврийг сахина.

1.12.4. Өрөөнд чийгтэй цэвэрлэгээг өдөр тутам хийж, ахуйн хог хаягдлыг ажиглах байрнаас гаргасан хуваарийн дагуу өрөөний үүдэнд гаргаж тавина.

1.12.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон харуул хамгаалалтын ажилтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж, доромжлох, заналхийлэх, биед нь халдах аливаа үйлдэл гаргахыг хориглоно.

1.12.6. Өрөөнөөс гарах, бусдыг өдөөн турхирах, архи, мансууруулах бодис хэрэглэхийг хориглоно.

1.12.7. Байрны эд хогшлыг эвдэж гэмтээхгүй, ариг гамтай ашиглана.

1.12.8. Тусгаарлан ажиглах байранд байх хугацаанд гарсан зардлыг Улсын онцгой комиссоос батлагдсан жишгийн дагуу төлнө.

Хүснэгт 10. Ажиглалтын хуудас

| Өдөр | Шинж тэмдэг илэрсэн эсэх | Халуурах ≥37.1 хэм | Хоолой өвдөх | Хуурай ханиалгах | Ядарч сульдах | Амьсгаа дах | Бусад (Бичих) |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |
| 2 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |
| 3 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |
| 4 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |
| 6 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |
| 7 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |
| 8 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |
| 9 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |
| 10 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |
| 11 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |
| 12 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |
| 13 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |
| 14 | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | Тийм I__I<br>Үгүй I__I | |

### 1.13. Ажиглалтын байранд эргэлт оруулах

1.13.1. УОК-ын шийдвэрийн дагуу ажиглалтын хугацаанд 3 удаа шаардлагатай хувийн хэрэглээний зүйлс, ном, сэтгүүл, бичгийн хэрэгсэл, ариун цэврийн хэрэгсэл, хувцас, нэг удаагийн хэрэглээний савтай хоол хүнс, сүү, тараг, чихэр, жимс, гарын саван зэргийг эргэлтээр оруулж болно.

1.13.2. Халуун бууруулах, өвчин намдаах эм оруулахыг хориглоно.

1.13.3. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн эргэлтийн эд зүйлсийг онцгой байдлын ажилтнаас авч иргэдэд хүлээлгэн өгөхдөө өрөөний үүдний ширээн дээр байрлуулна.

### 1.14. Ажиглалтын байранд сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах хариу арга хэмжээ

1.14.1. Ажиглах байрны эмч иргэд, үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад халдварын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд коронавируст халдварын сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирч байгаа эсэхийг үнэлнэ.

1.14.2. Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирч байгаа иргэн өрөөндөө ганцаараа байрлаж байгаа бол өрөөнд нь, гэр бүл, асран хамгаалагчтайгаа хамт байрлаж байгаа бол түр тусгаарлах өрөөнд тусгаарлан, нийслэлд ХӨСҮТ-ийн 100, 80086829 дугаарын утсанд, орон нутагт холбогдох эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэж шилжүүлнэ.

1.14.3. Сэжигтэй тохиолдлыг ажиглах байрнаас шилжүүлсний дараа нийслэлд ЗӨСҮТ-ийн 70284393 дугаарын утсанд холбогдож, аймагт ЗӨСТ, сум, тосгонд сум, тосгоны эрүүл мэндийн төвийн мэргэжлийн багийг дуудан, байрлаж байсан өрөө, түр тусгаарлах өрөө болон гарах хэсэгт эцсийн халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.

1.14.4. Халдваргүйжүүлэлт хийсэн хэсгүүдийг нэг цагийн дараа угааж цэвэрлэнэ.

1.14.5. Эмнэлэг, сувиллаас бусад үйлчилгээний байрыг ажиглах байраар ашиглаж байгаа бол сэжигтэй тохиолдол илэрсэн үед түүний хог хаягдлыг аюултай хог хаягдал гэж үзэн, халдваргүйжүүлэлт хийсэн байгууллагад битүүмжлэн өгч явуулна.

**1.15. Ажиглах байрнаас гарсан иргэдийг гэрт нь тусгаарлан үргэлжлүүлэн хянах**

1.15.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтний үүрэг:

1.15.1.1. Ажиглах байрны эмч, эмнэлгийн мэргэжилтэн иргэний овог, нэр, нас, хүйс, холбоо барих утас, оршин суугаа гэрийн хаяг зэргийг ажиглах байрнаас гарахаас 48 цагийн өмнө баталгаажуулж, ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгжийн Google.sheet файлын "Нэмэлт мэдээлэл" талбарт байршуулна.

1.15.1.2. Харьяалах сум, дүүрэг, өрх, тосгоны эмч гэрийн ажиглалтад шилжсэн иргэнийг бүртгэн авч, эрүүл мэндийн байдлыг хянаж, шаардлагатай тохиолдолд холбоо барих утасны дугаарыг өгч, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ. Хэрэв иргэнд төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай бол хяналт хийж байгаа харьяа онцгой байдал, цагдаа, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт мэдээлж, харьяаллын дагуу төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээнд хамруулна.

1.15.1.3. Иргэнд коронавируст халдварын сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон шинж тэмдэг илэрвэл эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийслэлд 100, 80086829 дугаарын утсанд, орон нутагт харьяа эрүүл мэндийн байгууллагад хандана.

1.15.1.4. Харьяалах сум, дүүрэг, өрх, тосгоны эмч гэрийн ажиглалтад байгаа иргэдийн нэгдсэн мэдээг аймаг, нийслэлийн ЭМГ-т, аймаг, нийслэлийн ЭМГ нь ХӨСҮТ-д мэдээлнэ.

1.15.1.5. Иргэн гэрийн ажиглалтад байх хугацаанд хаягандаа байхгүй, гэрээсээ гарсан тохиолдолд Зөрчлийн тухай, Эрүүгийн тухай хуульд заасны хариуцлага хүлээлгэхийг сануулна.

**1.16. Гэрийн ажиглалтад байгаа иргэний үүрэг**

1.16.1. Гэрийн ажиглалтад шилжсэн даруйдаа харьяалах өрх, сум, тосгоны эмчид утсаар мэдээлнэ.

1.16.2. Гэртээ 14 хоног өөрийгөө тусгаарлан ажиглах ба гэрээсээ гарах, зочин урихыг хориглоно.

1.16.3. Биеийн халуунаа өдөрт 2-оос доошгүй удаа хэмжиж, өөрийн эрүүл мэндийн байдалд хяналт тавих ба ямар нэгэн шинж тэмдэг илэрсэн даруйд харьяалах өрх, сум, тосгоны эмчид утсаар мэдээлнэ.

1.16.4. Хэрэв гадаадын иргэн бол Интермед эмнэлгийн 80105577, SOS medica эмнэлгийн 91913122 утсанд хандаж, зөвлөгөө авна.

**1.17. Ажиглах байрны хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, устгах**

1.17.1. Ажиглах байр, өрөө, хоол үйлдвэрлэл, харуул, хяналтын ажилтны хэсгээс гарах ариун цэврийн цаас, лааз, шил, хуванцар сав, цаасан хайрцаг, хүнсний ногооны хальс, хоолны үлдэгдэл зэрэг энгийн хог хаягдлыг хар өнгийн уутанд цуглуулна.

1.17.2. Ажиглах байранд үүрэг гүйцэтгэж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, алба хаагч болон бусад ажилтны хэрэглэсэн хамгаалах хувцас, хэрэгсэл болох нэг удаагийн амны хаалт, бээлий, халад, нүдний шил, малгай болон гутлын улавч, тарианы хөвөн, дуслын систем, живх зэргийг шар өнгийн уутанд цуглуулна.

1.17.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгдсэн тарианы ампул, зүү тариур зэрэг хурц үзүүр, иртэй хог хаягдлыг аюулгүй хайрцагт цуглуулна.

1.17.4. Хөтөвчийг цэвэрлэж, хлор агуулсан уусмалаар халдваргүйжүүлнэ.

1.17.5. Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламж нүхэн жорлонг гүний усны түвшингээс 1.5 метрээс багагүй, усны эх үүсвэрэс 30 метрээс багагүй зайд байхаар тооцож зохион байгуулна.

1.17.6. Бохир усны цооног, нүхэн жорлонд долоо хоногт 2-3 удаа халдваргүйжүүлэлт хийнэ.

1.17.7. Тусгаарлан ажиглах байранд сэжигтэй тохиолдол бүхий үйлчлүүлэгчийн өрөөнөөс гарах бүх хог хаягдлыг "аюултай" гэж үзэн, шар өнгийн уутанд цуглуулна.

1.17.8. Халуун хэмжигч багажны хугацаа дууссан зай, өдрийн гэрэл, даралт хэмжигч эвдэрсэн багаж зэрэг хүнд металл агуулсан, хугацаадуусссан, хагарчгэмтсэн, бохирдсон эм, халдваргүйжүүлэх бодис агуулсан сав зэргийг хүрэн өнгийн уутанд цуглуулна.

1.17.9. Ажиглалтын өрөө, харуул, хяналтын ажилтны хэсгээс хар өнгийн уутанд цуглуулсан энгийн хог хаягдлыг өдөрт 1 удаа, хоол үйлдвэрлэлээс гарч байгаа хог хаягдлыг тухай бүр авч, энгийн хог хаягдлын цэгт төвлөрүүлнэ.

1.17.10. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан аюултай гэж үзэх шар, хүрэн өнгийн ууттай болон аюулгүй хайрцагтай хог хаягдлыг өдөрт 1 удаа тухайн байранд зохион байгуулсан цэгт төвлөрүүлнэ.

1.17.11. Энгийн хог хаягдлын цэгт төвлөрүүлсэн хог хаягдлыг тухайн орон нутгийн тохижилт үйлчилгээний компанитай хийсэн гэрээний дагуу тээвэрлэж устгана.

1.17.12. Аюултай хог хаягдлыг Улаанбаатар хотод "Элемент" ХХК-д өдөр бүр хүлээлгэн өгч бүртгэл хөтөлнө, орон нутагт тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллага зохион байгуулна.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны
04 сарын 29-ны өдрийн А/269 дугаар
тушаалын наймдугаар хавсралт

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ҮЕД ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ ТҮР ЗААВАР

Коронавируст халдвар (COVID-19)-ын үед халдваргүйжүүлэлт хийх үйл ажиллагаанд энэхүү түр зааврыг мөрдөнө.

Коронавируст халдвар (COVID-19)-ын үед урьдчилан сэргийлэх болон голомтын (байнгын, эцсийн) халдваргүйжүүлэлтийг хийнэ.

Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг эрүүл мэндийн байгууллага, шалган нэвтрүүлэх пост, агаарын болон нийтийн тээврийн үйлчилгээний байгууллага, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний газар, сургалтын боловсролын байгууллага, цэргийн анги, хорих анги, түр саатуулах байр, асрамжийн газар зэрэг бүх байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх зааврын дагуу тогтмол хийнэ.

Эцсийн халдваргүйжүүлэлтийг өвчтөн эдгэрч гарсан, шилжсэн, нас барсаны дараа тухайн эмнэлгийн палат, цогцос хадгалагдаж байсан байр, өвчтөн байсан бусад орчинд нийслэлд ЗӨСҮТ, холбогдох мэргэжлийн байгууллага, аймаг, сумын түвшинд ЗӨСТ, БОЭТ, нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хийнэ.

## Нэг. Халдваргүйжүүлэлт хийх нийтлэг шаардлага

1.1. Халдваргүйжүүлэлтэд хэрэглэх бодис нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай, хэрэглэх заавар нь баталгаажсан, хугацаа дуусаагүй, сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй, хаяг шошго тодорхой байна.
1.2. Голомтын халдваргүйжүүлэлтийг тухайн байгууллагын эмч, эрүүл ахуйч, хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтан, менежер, дотоод хяналтын ажилтны хяналтанд мэргэшсэн ариутгагч хийнэ.
1.3. Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийхэд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлчилгээний ажилчдад халдваргүйжүүлэх бодисыг найруулах арга, аюулгүй ажиллагааны зааварчилгааг урьдчилан өгсөн байна. Аж ахуй нэгж, байгууллагад урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг хийхийн өмнө эд юмсын гадаргуу дээрх бохирдлыг арилгаж, цэвэрлэгээг сайтар хийнэ.
1.4. Халдваргүйжүүлэлт хийхдээ бодис, хувин, хэмжээст сав, алчуур, резинэн бээлий, хогийн уут зэргийг урьдчилан бэлтгэж, амны хаалт, резинэн бээлий зэргийг өмссөн байна.
1.5. Халдваргүйжүүлэлт хийхдээ энэхүү зааврын Хүснэгт 11-д заасан бодисуудаас аль нэгийг нь сонгож хэрэглэнэ.
1.6. Санамсаргүй тохиолдлоор халдваргүйжүүлэлтийн бодис нүд, ам, хамрын салстаар орсон тохиолдолд усаар сайтар угааж, амьсгалын замаар орсон бол цэвэр агаарт гаргана. Халдваргүйжүүлэлтийн бодисыг хүүхдээс хол байлгана.

**Хоёр. Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт**

**2.1. Тээврийн хэрэгсэлд хийх халдваргүйжүүлэлт**

2.1.1. Зорчигчийг хүлээн авахаас өмнө агаарын хөлөг болон галт тэрэг, ачааны болон суудлын машин, автобус зэрэг нийтийн тээврийн хэрэгслийн дотор хана, шал, цонх, суудал, цонх, суудлын бариул, суудлын даруулга, суудлын тавцан зэрэг хүний гар хүрэлцдэг бүх гадаргуу, ариун цэврийн өрөөг цэвэрлэж, халдваргүйжүүлнэ. Шүршиж халдваргүйжүүлсэн тохиолдолд нэг цагийн дараа чийгтэй цэвэрлэгээ дахин хийнэ.

2.1.2. Гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай бодисыг зорчигчид хэрэглэхэд хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулж, хэрэглээнд хяналт тавина.

2.1.3. Агаарын хөлөг, галт тэрэгний ариун цэврийн өрөөнд гарын саван, гар арчих цаасан алчуур байрлуулан гар угаах нөхцөлийг бүрдүүлж, аялалын явцад ариун цэврийн өрөөг 2 цаг тутамд, бохирдсон тохиолдол бүрт цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

2.1.4. Агаарын хөлөг, галт тэрэгний үйлчлэгч нь зорчигч, зорчигчийн эд зүйлтэй харьцах болон үйлчилгээ үзүүлсэний дараа үйлчилгээний тэргэнцэр, тавцанг цэвэрлэж, тухай бүр гараа халдваргүйжүүлнэ.

2.1.5. Галт тэрэг, аялалын явцад цонх, хаалгыг нээж агаар сэлгэлтийг тогтмол хийж, зорчигч буусан тохиолдолд тухайн суудал, тасалгааг цэвэрлэж, халдваргүйжүүлэлт хийнэ.

2.1.6. Агаарын хөлөгт зорчигчид хэрэглүүлсэн нөмрөг, чихэвч, галт тэргэнд цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийг халдваргүйжүүлсний дараа угааж, индүүднэ.

2.1.7. Зорчигчдоос сэжигтэй тохиолдол илэрсэн үед хоолны үлдэгдэл, аяга таваг, ариун цэврийн өрөөний хог хаягдал, хэрэглэсэн хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг тусгай зориулалтын уутанд цуглуулж, халдвартай хог хаягдал устгах журмын дагуу устгана.

2.1.8. Зорчигчийн гар утас, түлхүүр, хэтэвч зэрэг хувийн эд зүйлсийг устөрөгчийн хэт исэлтэй сальфеткаар арчих, ачаа тээш, гар цүнх, үүргэвчийг халдваргүйжүүлнэ.

2.1.9. Голомтот бүс нутгаас ирж буй тээврийн хэрэгслийн гадна тал, дугуйг халдваргүйжүүлэх уусмалаар шүршиж халдваргүйжүүлнэ.

2.1.10. Шалган нэвтрүүлэх товчоогоор нэвтэрч буй тээврийн хэрэгсэлд хийх халдваргүйжүүлэлтийг халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.

2.1.11. Голомтот бүс нутгаас ирж буй чингэлэг, ачаа тээш, бараа бүтээгдэхүүнийг гадна талаас нь халдваргүйжүүлэх уусмалаар шүршиж (хэт норгохгүй) халдваргүйжүүлнэ.

**2.2. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний газруудад хийх халдваргүйжүүлэлт**

2.2.1. Энэ хэсэгт нийтийн хоол, зах, худалдааны төв, тоглоомын газар, кинотеатр, чийрэгжүүлэх, бялдаржуулах төв болон спорт заал, саун бассейн, банк, үсчин гоо сайхан зэрэг бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд хамаарна.

2.2.2. Үйлчилгээний заал, орох, гарах хэсэгт гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай бодисыг хүртээмжтэй байршуулсан байна.

2.2.3. Ариун цэврийн өрөөнд гарын саван, гар арчих цаасан алчуур, гар угаах нөхцлийг бүрдүүлсэн байна.

2.2.4. Гар хүрч амархан бохирддог хаалганы бариул, унтраагуур, цахилгаан шатны дотор орчин, товчлуур, шатны бариул, компьютерийн гар, заагуур, гар болон телефон утас, зурагтын удирдлага, ширээ, сандлын түшлэг, нийтийн заалны сандал, лангуу, тавиур, барааны сагс, тэргэнцэр, мөнгөний болон бусад АТМ машины товчлуур, тамхи татах цэг зэргийг 2 цаг тутамд, бохирлогдсон тохиолдолд тухай бүр арчиж халдваргүйжүүлнэ.

2.2.5. Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний газруудад хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, сав, баглаа боодлыг хөргөгч, хөлдөөгч, зориулалтын агуулахад тохирох хэмд хадгалан, хүнстэй шууд харьцах тоног төхөөрөмжийг шингэн нэвчихгүй материалаар сайтар битүүмжилж, тоног төхөөрөмж, орчны эд зүйлсийг цэвэрлэн, халдваргүйжүүлнэ. Халдваргүйжүүлснээс хойш 1 цагийн дараа бодисын үлдэгдлийг цэвэр усаар угаана.

2.2.6. Үйлчилгээний газрудын цагаан хэрэглэл, биеийн болон гар нүүрний алчуур, хувцас, нөмрөг зэрэг зөөлөн эдлэлүүдийг үйлчлүүлэгчдэд хэрэглэсэн тухай бүр сольж халдваргүйжүүлэн, угааж индүүднэ. Усны шаахай, үсний сам, хайч, хумс арчилгааны зэрэг жижиг хэрэгслийг халдваргүйжүүлэн, цэвэр усаар сайтар зайлна.

2.2.7. Тоглоомын төвүүдийн бүх төрлийн тоглоомыг угаагч бодистой халуун усаар сайтар угаасны дараа 2%-ийн содын уусмалаар халдваргүйжүүлнэ.

2.2.8. Түр саатуулах байранд хэрэглэгдэж байгаа зөөлөн эдлэлийг 1 хүн хэрэглэсний дараа угааж индүүдэх, дезкамераар халдваргүйжүүлнэ.

2.2.9. Нийтийн ариун цэврийн өрөөний суултуур, угаалтуурыг 2 цаг тутамд, бохирлогдсон тухай бүрт халдваргүйжүүлэн, агааржуулалт хийнэ.

2.2.10. Үйлчилгээний заалны салхивчийг 2 цаг тутамд, дулааны улиралд тогтмол онгойлгож, агаар сэлгэлт хийнэ.

2.2.11. Өдөр бүр үйлчилгээ дуусcаны дараа шал, хаалга, орчны эд зүйлсийн гадаргууд чийгтэй цэвэрлэгээ хийж, халдваргүйжүүлэлт хийнэ. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийсний дараа цонх, хаалгыг нээж агаар сэлгэлт хийнэ.

2.2.12. Автомат болон механик агааржуулалтын системийн агаар шүүгчийг солин, агааржуулалтын шугам хоолойг цэвэрлэж, засвар үйлчилгээг үйлдвэрлэгчийн зааврын дагуу тогтмол хийнэ.

2.2.13. Худалдаа, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд өөрийн эзэлбэр газар дахь гадна орчны талбайд ил задгай хог хаягдлын хуримтлал үүсгэхгүйгээр хогийн савны тоо, хэмжээ хоорондын зайг тооцож байршуулан, хогийн сав, хогийн бункерээс хог хаягдлыг хуваарийн дагуу ачуулж, шүршиж халдваргүйжүүлнэ.

**2.3. Цэргийн анги, нэгтгэл, хорих анги, асрамж, халамжийн газарт хийх халдваргүйжүүлэлт**

2.3.1. Орох, гарах хэсэг, нийтийн үйлчилгээ, хоолны заал, ариун цэврийн өрөөнд спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх бодисыг хүртээмжтэй байршуулсан байна.

2.3.2. Ариун цэврийн өрөөнд гарын шингэн саван, нэг удаагийн цаасан алчуур байрлуулж, гар угаах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.3.3. Гар хүрч амархан бохирддог хаалганы бариул, унтраагуур, цахилгаан шатны дотор орчин, товчлуур, шатны бариул, компьютерийн гар, заагуур, гар болон телефон утас, зурагтын удирдлага, ширээ, сандлын түшлэг, нийтийн заалны сандал, лангуу, тавиур, барааны сагс, тэргэнцэр, мөнгөний болон бусад АТМ машины товчлуур, тамхи татах цэг зэргийг 2 цаг тутамд, бохирлогдсон тохиолдолд тухай бүр арчиж халдваргүйжүүлнэ.

2.3.4. Цонхны хөшиг, ширээ, суудлын бүтээлэг зэрэг зөөлөн эдлэлийг долоо хоног бүр угаалгын бодистой усаар угааж индүүднэ.

2.3.5. Шалыг өдөрт 1-2 удаа, бохирлогдсон тухай бүрт угаалгын бодистой усаар цэвэрлэн халдваргүйжүүлнэ. Өрөө тасалгаа, орцны цонхыг 2 цаг тутамд, дулааны улиралд тогтмол онгойлгож, агаар сэлгэлт хийнэ.

2.3.6. Ариун цэврийн өрөөг 2 цаг тутамд, бохирдсон тохиолдолд тухай бүр цэвэрлэж, халдваргүйжүүлнэ. Хөтөвчийг хэрэглэсэн тухай бүр халдваргүйжүүлж цэвэрлэнэ.

2.3.7. Хөнжил, гудас, орны бүтээлэг, дэр зэргийг долоо хоног бүр нар, салхинд 4-өөс доошгүй цаг байлгаж, дезкамерт халдваргүйжүүлнэ.

2.3.8. Үйлчлүүлэгчдийн орны цагаан хэрэглэл, бүтээлэг, гар, нүүрийн алчуур зэрэг зөөлөн эдлэлийг бохир хэрэгсэл зөөвөрлөх саванд хийж, угаалгын газарт хүргэн, халдваргүйжүүлж, 70 хэмээс дээш халуун усанд угааж, индүүднэ.

2.3.9. Бүх төрлийн тоглоомыг угаагч бодистой халуун усаар сайтар угаасны дараа 2%-ийн содын уусмалаар халдваргүйжүүлнэ.

2.3.10. Гадна орчны талбайд ил задгай хог хаягдлын хуримтлал үүсгэхгүйгээр хогийн савны тоо, хэмжээ, хоорондын зайг тооцож байршуулан, хогийн сав, бункерээс хог хаягдлыг ачуулж, халдваргүйжүүлнэ.

2.3.11. Сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед голомтын халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

**2.4. Нийтийн эзэмшлийн зам, талбайд хийх халдваргүйжүүлэлт**

2.4.1. Нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбай, үерийн далан, суваг, шуудууны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга хариуцаж зохион байгуулна.

2.4.2. Орцны хаалга, хаалганы бариул, шат, шатны бариул, цахилгаан шатны дотор тал, товчлуур, автомат цоожны товчлуур зэргийг тухайн аж ахуйн нэгж, албан байгууллага, Сууц өмчлөгчдийн холбоо хариуцан 2 цаг тутамд цэвэрлэж халдваргүйжүүлнэ.

2.4.3. Орц, хонгилын цонхыг 2 цаг тутамд нээж агаар сэлгэнэ.

2.4.4. Нийтийн эзэмшлийн тоглоомын талбай, тоглоом, чийрэгжүүлэлтийн төхөөрөмжүүд, сандал, сүүдрэвч зэргийг арчих эсвэл шүршиж халдваргүйжүүлнэ. Халдваргүйжүүлэх бодисыг хуурайгаар хэрэглэхгүй.

2.4.5. Нийтийн эзэмшлийн талбайд шүршиж халдваргүйжүүлэлт хийхдээ хөл хөдөлгөөн багассан ажлын бус цагаар хийж гүйцэтгэнэ.

2.4.6. Гадаад орчны агаарын хэм тэгээс ($0^0C$) бага үед гадаад орчны халдваргүйжүүлэлт хийхгүй.

2.4.7. Гадна орчны талбайд ил задгай хог хаягдлын хуримтлал үүсгэхгүйгээр хогийн савны тоо, хэмжээ, хоорондын зайг тооцож байршуулан, хогийн сав, бункерээс хог хаягдлыг тогтмол хугацаанд ачуулж, халдваргүйжүүлнэ.

2.4.8. Хогийн машиныг ажил дууссаны дараа өдөр бүр угааж цэвэрлэн, шүршиж халдваргүйжүүлнэ.

**2.5. Бие засах газар, нүхэн жорлон, хогийн нэгдсэн цэгт халдваргүйжүүлэлт хийх**

2.5.1. Нийтийн бие засах газарт харъяалах байгууллага өдөр тутам халдваргүйжүүлэх уусмал ашиглан цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг хийнэ.

2.5.2. Ариун цэврийн өрөөнд гарын угаах нөхцөлийг бүрдүүлж, спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх бодисыг хүрэлцэхүйц хэмжээгээр байршуулсан байна.

2.5.3. Нүхэн жорлон, бохир усны цооногийг зориулалтын халдваргүйжүүлэгч бодисоор үйлдвэрлэгчийн зааврын дагуу халдваргүйжүүлнэ. Хэрвээ зориулалтын бодис байхгүй бол 40%-ийн идэвхтэй гипохлорит кальциас 0.5%-ийн ажлын уусмал бэлтгэж, нэг $м^2$ талбайд 2 литр уусмал орохоор тооцож халдваргүйжүүлнэ. 1 л ажлын уусмал бэлтгэхдээ 40%-ийн идэвхтэй гипохлорит кальциас 12.5г хуурай бодисыг авч найруулна. Халдваргүйжүүлэлт хийсний дараа нүхэн жорлон, бохирын усны цооногийн тагийг 1-2 цаг хаалттай байлгана.

2.5.4. Нүхэн жорлон, бохирын усны цооногт дулааны улиралд сард нэг удаа, хүйтний улиралд гурван сард нэг удаа халдваргүйжүүлэлт хийнэ.

Хүснэгт 11. Халдваргүйжүүлэх бодисын найрлага, хэрэглээ

| Д/д | Бодисын нэр | Ажлын уусмал | Бодисын хэмжээ | Уусмалын хувь | Хэрэглэх зориулалт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Клорсепт | 5 л | 1 ш | 0.02% | Урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгсэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээ гэх мэт хатуу гадаргуу халдваргүйжүүлнэ. |
| | | 2 л | 1 ш | 0.05% | Урьдчилан сэргийлэх зорилгоор ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ. |
| | Жаве-лион | 10 л | 1 ш | 0.015% | Урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгсэл, өрөө, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | | | | | тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээ гэх мэт хатуу гадаргуug халдваргүйжүүлнэ. |
| | | 10 л | 2 ш | 0,03% | Урьдчилан сэргийлэх зорилгоор ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ. |
| | | 10 | 4 ш | 0.06% | Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ, сандал, тавиур, шүүгээ гэх мэт хатуу гадаргуу, бүх төрлийн зөөлөн эдлэлийг 1 цаг живүүлж халдваргүйжүүлнэ. |
| | | 10 | 7 | 0.1% | Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдвар гүйжүүлнэ. |
| 3 | ДП-2Т | 7.5 | 1 | 0.02% | Урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгсэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээ гэх мэт хатуу гадаргууг халдваргүйжүүлнэ. |
| | | 7.5 | 2 | 0.04% | Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед агаарын хөлөг болон галт тэрэг, нийтийн тээврийн хэрэгслэл, өрөө тасалгааны хаалга, хаалганы бариул, хана, цонх, шал, ширээ сандал, тавиур, шүүгээгээ гэх мэт хатуу гадаргуу, бүх төрлийн зөөлөн эдлэлийг 1 цаг живүүлж халдваргүйжүүлнэ |
| | | 7.5 | 5 | 0.1% | Голомтын эцсийн халдваргүйтгэлийн үед ариун цэврийн өрөөний угаалтуур,суултуур, шүршүүр, хана, шал, бусад хатуу гадаргууг халдвар гүйжүүлнэ. |
| 4 | 40%-ийн гипо-хлорид кальци /хуурай/ | 10 | 50 гр | 0.2% | Шингэн хаягдал, нүхэн жорлон, бохир усны цооногийг халдваргүйжүүлнэ. |
| | | 10 | 125 гр | 0.5% | Шингэн хаягдал, нүхэн жорлон, бохир усны цооногийг халдваргүйжүүлнэ. |
| 5 | Содын уусмал | 1 л | 20 гр | 2% | Бүх төрлийн хүүхдийн тоглоомыг халдваргүйжүүлнэ |

**Гурав. Голомтын халдваргүйжүүлэлт**

3.1. Коронавируст халдвар (COVID-19)-ын батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед голомтод эцсийн халдваргүйжүүлэлтийг нийслэлд Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ), аймаг, сумын түвшинд харьяа Зоонозын өвчин судлалын төв, ЗӨСТ-гүй газар нэгдсэн эмнэлэг хариуцан хийнэ.

3.2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар голомтын халдваргүйжүүлэлт хийх багийг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.

3.3. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийх тусгай мэргэжлийн төвүүд 5 ба түүнээс дээш, нийслэлийн түвшинд 4, аймгийн түвшинд 3, сумын түвшинд 2 багийг томилж, бэлэн байдлыг хангана.

3.4. Коронавируст халдвар (COVID-19)-ын дэгдэлт гарч, ЗӨСҮТ, ЗӨСТ-ийн хүчин чадал хүрэлцэхгүй болсныг мэдэгдсэн тохиолдолд тусгай мэргэжлийн төвүүд, аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвөөс томилогдсон нэмэлт халдваргүйжүүлэлтийн багийг дайчлан ажиллуулна.

3.5. Томилсон багийн бүрэлдэхүүнийг тухайн эрүүл мэндийн байгууллага ариутгал, халдваргүйжүүлэлтийн чиглэлээр сургаж, дадлагажуулсан байна.

3.6. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй, магадлалтай болон батлагдсан тохиолдол эмнэлэгт бүртгэгдсэн үед эцсийн халдваргүйжүүлэлтийг тухайн эмнэлгийн томилж, бэлтгэгдсэн халдваргүйжүүлэлтийн баг хийж гүйцэтгэнэ.

3.7. Голомтод эцсийн халдваргүйжүүлэлтийг өвчтний гэр, ажлын байр, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн болон тусгаарласан өрөө, өвчтөн нас барсан газар, цогцос түр хадгалах байр, зөөвөрлөсөн тээврийн хэрэгсэлд хийж гүйцэтгэнэ.

3.8. Коронавируст халдвар (COVID-19)-ын сэжигтэй тохиолдлын онош батлагдаагүй байгаа нөхцөлд ажиглалтын байранд голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийхгүй.

3.9. Халдваргүйжүүлэлтийн бодис нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаажилттай, хадгалах хугацаа дуусаагүй, хаяг шошго, сав, баглаа бүрэн бүтэн, хэрэглэх аргачлал тодорхой байх бөгөөд үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж хэрэглэнэ.

3.10. Давтан хэрэглэх эмнэлгийн багаж хэрэгслийг цэвэрлэх халдваргүйжүүлэх, ариутгахад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ЭМС-ын 2019 оны 537 дугаар тушаалын 2 дугаар хавсралт)-аас баталсан зааврыг мөрдөнө.

3.11. Голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийхдээ томилогдсон баг нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ЭМС-ын 2017 оны А/161 дүгээр тушаал)-аас баталсан халдвараас сэргийлэх, биоаюулгүй ажиллагааны зааврыг мөрдөн ажиллана.

3.12. Голомтын халдваргүйжүүлэлт хийхдээ хүснэгт 12-д заасан халдваргүйжүүлэлтийн бодисоос сонгож, үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.

**3.13. Голомтын халдваргүйжүүлэлтийн багийн үүрэг**

3.13.1. Голомтод халдваргүйжүүлэлт хийх баг нь тархвар судлагч эмчийн хяналтад ажиллана.

3.13.2. Халдваргүйжүүлэлтийн багийн гишүүд нэг удаагийн иж бүрэн хамгаалах хувцас, хэрэгслийг халдваргүй бүс буюу ногоон бүсэд өмсөнө.

3.13.3. Голомтод эцсийн халдваргүйжүүлэлт хийх эрүүл мэндийн ажилтан нь нэг удаагийн малгай, шүүлтүүртэй амны хаалт, нүдний шил, нүүрний хаалт, бээлий (давхар резинен бээлий), ханцуйвч, комбинзон, нэг удаагийн халад (шаардлагатай тохиолдолд давхар өмсөх), хормогч (шаардлагатай тохиолдолд), ус нэвтэрдэггүй

түрийтэй гутал зэрэг нэг удаагийн хамгаалах хэрэгслийг халдвараас сэргийлэх зааврын дагуу өмсөнө.
3.13.4. Халдваргүйжүүлэлтийн бодисыг цэвэр саванд зааврын дагуу найруулна. Уусмалын үлдэгдэл дээр шинээр уусмал нэмж найруулахыг хориглоно.
3.13.5. Халдваргүйжүүлэлт хийхээс өмнө байрны цонх, хаалгыг хаана.
3.13.6. Эцсийн халдваргүйжүүлэлт хийхэд байрны гадна тал хаалганаас эхэлж, гадна талаас дотогш болон дээрээс доош чиглэлээр халдваргүйжүүлэлт хийнэ.
3.13.7. Өрөө тасалгаанд халдваргүйжүүлэлт хийхдээ гар хүрэх газруудад аль болох арчиж халдваргүйжүүлнэ. Тааз, хананы дээд хэсэг, их талбайг хамарсан халдваргүйжүүлэлт хийх үед автомакс болон шүршигч ашиглан сайтар шүршинэ.
3.13.8. Тоног, төхөөрөмж, ахуйн хэрэглээний эд, зүйлсийн гадаргууг халдваргүйжүүлэх бодис бүхий алчуураар арчина.
3.13.9. Хоол, хүнсний сав, аяга тавга зэрэг хэрэгслийг зориулалтын угаагч шингэн бүхий халуун усаар угаана. Халдваргүйжүүлэх бодис хэрэглэх шаардлагагүй.
3.13.10. Халдваргүйжүүлэлт хийж дууссаны дараа хэрэглэсэн хамгаалах хувцас хэрэгслийг завсрын /шар/ бүсэд зааврын дагуу тайлна.
3.13.11. Халдваргүйжүүлэлт хийснээс хойш 1-2 цагийн дараа чийгтэй цэвэрлэгээ хийж, өрөөг агааржуулна.
3.13.12. Хамгаалах хувцас хэрэгсэл болон халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааны үед гарсан халдвартай хог хаягдал цуглуулах шар уут бүхий хог хаягдлыг зориулалтын тагтай саванд хийж, савны гадна талыг халдваргүйжүүлэлтийн уусмалаар шүршиж, зөөвөрлөн хог хаягдлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/505 дугаар тушаал)-аас баталсан "Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар"-ын дагуу устгана.
3.13.13. Ойрын хавьтал, өвчтөн, цогцос зөөвөрлөсөн (нүүлгэн шилжүүлсэн) тээврийн хэрэгсэлд тухай бүр эцсийн халдваргүйжүүлэлтийг заавал хийнэ.

## Дөрөв. Хилийн нэвтрэх цэг, гаалийн хяналтын бүсэд хийгдэх халдваргүйжүүлэлт

4.1. Улсын хилээр нэвтэрч буй бүх төрлийн тээврийн хэрэгсэлд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг хилийн боомт дахь алба, хэлтсээс хүснэгт 11-д заасны дагуу гүйцэтгэнэ.
4.2. Экспортын ашигт малтмалын тээвэрлэлт хийж буй ачааны машин болон жолоочийн бүхээгийн халдваргүйжүүлэлтийн зориулалтын ариутгалын төхөөрөмж, багаж ашиглан хилийн боомт дахь алба, хэлтсээс халдваргүйжүүлж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын хангалт, бохир усны зайлуулалтын асуудлыг тээвэр гүйцэтгэгч аж ахуйн нэгж хариуцна.
4.3. Халдварын голомт бүхий бүс нутгаас ирж буй чингэлэг, вагон, ачаа тээшинд гадаргуугийн урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэж, ариутгалын чанар, үйл ажиллагаанд хилийн боомт дахь алба, хэлтсээс хяналт тавина.
4.4. Халдварын сэжигтэй зорчигч тээвэрлэсэн ирсэн онгоц, галт тэрэг, ачааны болон суудлын машин, автобус, сэжигтэй болон ойрын хавьтлыг эрүүл мэндийн байгууллагад хүргэсэн тээврийн хэрэгсэл, түр тусгаарлах өрөө, хатуу шингэн хог хаягдлын эцсийн халдваргүйжүүлэлтийг ЗӨСҮТ, орон нутагт ЗӨСТ болон зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

4.5. Голомттой бус нутгаас ирсэн зорчигч, жолоочийн гадаад паспорт, гар тээш, тээврийн баримт бичиг, карго ачаа, шуудангийн илгээмж болон тархвар судлалын заалтаар шаардлагатай тохиолдолд зарим тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлтийг ЗӨСҮТ, орон нутагт ЗӨСТ, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
4.6. Зорчигч, жолоочийн гар тээш, эд, зүйлс, карго ачаа, шуудангийн илгээмжийг халдваргүйжүүлснээс хойш 2 цагийн дараа, ажиглалт орсон иргэний бүртгэгдсэн тээшийг 5 хоногоос хэтрэхгүй хугацааанд тус тус олгоно.
4.7. Импортын давхар савалгаатай хүнсний бүтээгдэхүүнд зөвхөн гадаргуугийн халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
4.8. Хилийн боомтын нутаг дэвсгэрийн шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийн үйл ажиллагааг боомт дахь алба, хэлтэс хариуцаж, хамтарсан тандалт судалгааг ЗӨСҮТ, орон нутагт ЗӨСТ-тэй хамтран гүйцэтгэнэ.
4.9. Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажилтанг мэргэжлийн байгууллагатай хамтран тогтмол сургалтад хамруулна.

Хүснэгт 12. Коронавируст халдвар (COVID-19)-ын голомтод халдваргүйжүүлэлт хийх аргачлал

| Д/д | Халдваргүйжүүлэх зүйлсийн нэр | Халдваргүйжүүлэх арга | Халдваргүйжүүлэх бодисын нэр | Үйлчлэх хугацаа | Зарцуулах хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1. | Цэр идээ, шээс, өтгөн, цус, ялгадасны сав, бусад | -Холих<br>-Дүүргэж хийх | -0.1%-ийн жавелион<br>-0.04 %-ийн ДП-2Т<br>-0.05%-ийн хлорклийн | 1 цаг | ЭМС-ын 161 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтын 3 дугаар заалтыг баримтална. |
| 2. | Асгарсан, цацагдсан цус, биологийн шингэнээр бохирлогдсон талбай, гадаргуу | -Шүрших | - 0.06%-ийн жавелион<br>- 0.04 %-ийн ДП-2Т<br>- 0.05%-ийн хлорклийн | 1 цаг | ЭМС-ын 537 дугаар тушаалын 6 дугаар хавсралтын 3 дугаар заалтыг баримтална. |
| 3 | Зөөлөн эдлэл /Цагаан хэрэглэл, хувцас гэх мэт/ | -Дезкамер | -Уур агаарын холимог ( 85 – 90⁰ ) | 45 минут | ЭМС-ын 537 дугаар тушаалын 8 дугаар хавсралтыг баримтлана. |
| | | -Автоклав | 1.5 атм 126⁰С | 30 минут | |
| | | -Дүрэх<br>-Живүүлэх | -0.06%-ийн жавелион<br>-0.04 %-ийн ДП-2Т | 1 цаг | Халдваргүйжүүлэх уусмалд дүрэх, живүүлэх аргыг хэрэглэнэ. |
| 4 | Орон байр, гэр, майхан тавилгын гадаргуу, өвчтний өрөө (хана, тааз туурга, хаалга, цонх, тавцан, шал, ажлын ширээ, ор, шүүгээ, бусад эд зүйлс) | -Агаарт мананцар үүсгэхгүй шүрших<br>-Арчих | -0.06%-ийн жавелион<br>-0.04 %-ийн ДП-2Т<br>-0.05%-ийн хлорклийн | 1-2 цаг | Халдваргүйжүүлэх уусмалаар арчина. |
| 5. | Өрөө, тасалгааны агаарыг халдваргүйжүүлэх | -Мананцар үүсгэж шүрших | -0.03%-ийн жавелион<br>-3%-ийн устөрөгчийн хэт исэл | 1 цаг | -1 м2 талбайд 100 мл байхаар тооцож шүршинэ.<br>-1 м2 талбайд 40 мл байхаар тооцож шүршинэ. |
| 6. | Өвчтний хоолны үлдэгдэлтэй сав, суулга, аяга, таваг | Угаах | -2%-ийн содын уусмал эсвэл зориулалтын угаагч шингэнээр угаах | 30 минут | Угаана. |
| 7. | Өвчтөн ба цогцос | -Шүрших | -3%-ийн устөрөгчийн | 1 цаг | -1 $м^2$ талбайд 500 мл |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зөөврлөсөн тээврийн хэрэгсэл | -Арчих | хэт исэл<br>-0.06%-ийн жавелион<br>-0.04%-ийн ДП-2Т<br>-0.05%-ийн клорклийн | | халдваргүйжүүлэх бодис хэрэглэхээр тооцож шүршинэ.<br>-Халдваргүйжүүлэх уусмалыг найруулж арчина. |
| 8. | Ил задгай нүхэн жорлон | -Шүрших | Гипохлорит кальци | | -1 $м^2$ талбайд 500 мл бодис байхаар тооцож шүршинэ.<br>-Хлорын шохойн 20-40%-ийн сүүн уусмалыг бэлтгэхдээ 2-4 кг хуурай хлорын шохойг бага зэргийн усыг жигд холимог болтол сайтар хольж хутгаад, 10 л хүртэл ус нэмж, тасалгааны хэмд 24 цаг тавина. Үүссэн тунгалаг уусма лыг ашиглана. |

Эрүүл мэндийн сайдын 2020 оны
04.сарын 29.-ны өдрийн А/269 дугаар
тушаалын есдүгээр хавсралт

# ГОЛОМТОТ БҮС НУТГААС АГААРЫН ХӨЛГӨӨР ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭХЭД БАРИМТЛАХ ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ТҮР ЗААВАР

Коронавируст (COVID-19) халдварын голомтот бүс нутгаас зорчигчдыг агаарын хөлгөөр тээвэрлэх үед агаарын хөлгийн дарга, нисгэгч, үйлчлэгч, томилогдсон албан хаагч /эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, эмч / болон зорчигчдыг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэхэд энэхүү зааврыг мөрдөнө.

**Нэг. Нислэгийн өмнө**

1.1. Хилийн мэргэжлийн хяналтын албаны эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагч нь нисгэгч, агаарын хөлгийн үйлчлэгч, томилогдсон албан хаагчдыг хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөх, тайлах, гарын ариун цэвэр сахих зэрэг халдвараас сэргийлэх мэдээлэл, зөвлөмжөөр хангана.

1.2. Багийн гишүүд хувийн /биед тохиромжтой хувцас өмсөх, нислэгийн өмнө хоол, ундыг тохируулан хэрэглэх гэх мэт/ бэлэн байдлыг хангана.

1.3. Нислэгийн явцад багийн гишүүдэд шаардагдах нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслийн багцыг 3 ээлжээр тооцож бэлтгэн бэлэн байдлыг хангана.

1.4. Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн багцад шингэнд тэсвэртэй комбинзон, нэг удаагийн малгай, шүүлтүүртэй амны хаалт (95 хувиас дээш шүүлтүүртэй), нэг удаагийн бээлий, нүдний шил эсвэл нүүрний хаалт, гутлын гадуурх улавч орно.

1.5. Нислэгийн явцад шаардагдах гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай бодис, халуун хэмжигч, чагнуур, даралтын аппаратыг халдваргүйжүүлэхэд хэрэглэгдэх 70 хувийн спирттэй хөвөн, гадаргуун халдваргүйжүүлэх 0.02%-ийн клорсепт, 0.015%-ийн жавелионы уусмал, автомакс, хог хаягдал цуглуулах шар өнгийн уут, цэвэрлэгээний хэрэгслийг бэлтгэж, бэлэн байдлыг хангана.

1.6. Зорчигчдод хэрэглүүлэх нэг удаагийн амны хаалтыг нислэгийн явцад 2 цаг тутамд солихоор тооцож бэлтгэнэ.

1.7. Зорчигчдын гадаад паспортыг цуглуулах, ил харагдахуйц, битүүмжлэх боломжтой уутыг бэлтгэнэ.

1.8. Нислэгийн үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх эм тариа, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангана.

1.9. Агаарын хөлгийн дарга, нисгэгчид нь агаарын хөлгийн үйлчлэгч, томилогдсон албан хаагчдаас тусдаа бүхээгийн арын ариун цэврийн өрөөг хэрэглэх бөгөөд тэмдэглэгээ хийгдсэн байна.

1.10. Агаарын хөлгийн үйлчлэгч, томилогдсон албан хаагчид нь зорчигчдоос тусдаа ариун цэврийн өрөөг хэрэглэх бөгөөд тэмдэглэгээ хийгдсэн байна.

1.11. Ариун цэврийн өрөөнд гар угаах шингэн саван, цаасан алчуур, гар халдваргүйжүүлэгчийг хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулсан байна.

1.12. Хог хаягдал цуглуулах шар уут бүхий хогийн савыг шаардлагатай цэгүүдэд хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулна.

1.13. Зорчигчдын суудал бүрт нислэгийн үед баримтлах санамж, анхааруулга байрлуулсан байна.

1.14. Нисгэх багийн гишүүд нислэгийн явцад хооллох бол хоол хүнсийг агаарын хөлгийн бүхээгт урьдчилан байрлуулсан байна.

1.15. Агаарын хөлгийн дарга, нисгэгч, агаарын хөлгийн үйлчлэгч, томилогдсон албан хаагчид явах чиглэлд хамгаалах хувцас хэрэгслийг өмсөхгүй.
1.16. Зорчигчдыг онгоцонд оруулахын өмнө биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлж, амны хаалтыг сольж зүүлгэнэ.
1.17. Агаарын хөлөгт зорчигчдыг оруулахдаа бөөгнөрөл үүсгэхгүйгээр арын суудлын зорчигчдыг эхлэн суулгахыг зарлах ба зорчигч хоорондын зайг 1-2 метр байхаар зохион байгуулна. Хүндэтгэх шалтгаантай зорчигчийг эхэнд нь оруулна.

**Хоёр. Нислэгийн явцад**

2.1. Агаарын хөлгийн дарга, нисгэгч, агаарын хөлгийн үйлчлэгч, томилогдсон албан хаагчид ирэх чиглэлд зорчигчдыг хүлээж авахаас өмнө хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмссөн байна.
2.2. Агаарын хөлгийн дарга, нисгэгч нь зорчигчид агаарын хөлөгт суухаас өмнө бүхээгт орсон байна.
2.3. Бүхээгийн агаар сэлгэлтийг зорчигчдын заалны агаартай холихгүйгээр тусад нь хийнэ.
2.4. Нислэгийн явцад агаарын хөлгийн дарга, нисгэгч нь бүхээгийн хаалгыг нээхгүй, агаарын хөлгийн үйлчлэгч, томилогдсон албан хаагчид, зорчигчтой шууд харьцахгүй, шаардлагатай тохиолдолд дотуур холбоогоор холбогдоно.
2.5. Зорчигчийг тасалбарт бичигдсэн суудалд суулгах бөгөөд онцын шаардлагагүй бол босч явахгүй, суудал солихгүй, бусад зорчигчтой харьцахгүй, ярихгүй байх, хоол идэхгүй, эд зүйлс солилцохгүй байхыг дотуур холбоогоор анхааруулж, хяналт тавина.
2.6. Зорчигчдыг суудалдаа суусны дараа эрүүл мэндийн мэдүүлэг хуудсыг зөвлөмжийн хамт тарааж, биеийн халууныг 2 цаг тутамд хэмжинэ.
2.7. Зайнаас халуун хэмжихэд биеийн халуун 37.1 хэмээс дээш тохиолдолд 3 удаагийн давтамжтайгаар хэмжилт хийж, халуунтай нь тогтоогдвол шүүлтүүртэй амны хаалт /N95/-ыг зүүлгэж, бусад зорчигчдоос тусгаарлана.
2.8. Халдварын сэжигтэй тохиолдлыг агаарын хөлгийн даргад дотуур холбоогоор мэдээлж, агаарын хөлгийн дарга нь Монгол улсын агаарын хилийн зурваст ормогц Нислэг хөдөлгөөний үйлчилгээний албанд мэдээлнэ.
2.9. Улсын байцаагч зорчигчдын эрүүл мэндийн мэдүүлгийн хуудсыг бүрэн бөглөсөн эсэхэд хяналт тавьж, халууны хэмжилтийг хуудасны нүүрэн талд тэмдэглэж, зургаар баталгаажуулан, мэдээллийн сан үүсгэнэ.
2.10. Улсын байцаагч зургаар баталгаажуулсан эрүүл мэндийн мэдүүлгийн хуудсыг шар өнгийн уутанд цуглуулж, амыг сайтар битүүмжилнэ.
2.11. Зорчигчдын амны хаалтыг 2-3 цаг тутамд, бохирдсон тохиолдолд тухай бүр солиулах ба бохир амны хаалтыг суудлын урд байрлах цаасан уутанд хийж, амны хаалтыг шар өнгийн хогийн уутанд цуглуулж, гарыг халдваргүйжүүлнэ.
2.12. Нислэгийн үед агаарын хөлгийн дарга, нисгэгчид, хөлгийн үйлчлэгч, томилогдсон албан хаагч, зорчигчид амны хаалтыг тайлахыг хориглоно.
2.13. Нислэгийн үед зорчигчийн биеийн байдал тавгүйтэх, эмчийн зөвлөгөө, тусламж шаардлагатай бол хонх дарж, үйлчилгээний ажилтанд мэдэгдэхийг анхааруулан, их эмч тусламж үйлчилгээг үзүүлнэ.
2.14. Амь насанд аюултай нөхцөл байдал үүсээгүй бол тариа болон бусад эмнэлгийн ажилбар хийхийг хориглоно.
2.15. Зорчигчдод нислэгийн явцад хоолоор үйлчлэхгүй.
2.16. Шаардлагатай тохиолдолд зорчигчдод ус өгөх бол нэг удаагийн хэрэглээний аягыг ашиглан тавиур дээр байрлуулан өгнө. Гараас гарт өгөхийг хориглоно. Үйлчилгээ үзүүлсний дараа тавиурыг халдваргүйжүүлнэ.

2.17. Агаарын хөлгийн үйлчлэгч нь ариун цэврийн өрөөний суултуур, гар угаагуур, хаалганы гадна, дотно бариул, бусад хүрэлцэхүйц гадаргуун 1 цаг тутамд автомаксаар шүршиж, халдваргүйжүүлнэ.
2.18. Цугларсан хог хаягдлыг шар өнгийн уутанд цуглуулан амыг сайтар битүүмжилнэ. Уутыг хэт дүүргэхгүй. Хэрэглэсэн хамгаалах хувцас, бусад хог хаягдлыг аюултай хог хаягдал цуглуулах уутанд хийнэ.
2.19. Зорчигчдын гадаад паспортыг урьдчилан бэлтгэсэн уутанд цуглуулж, битүүмжилнэ.

**Гурав. Агаарын хөлөг газардсаны дараа**

3.1. Агаарын хөлгийн дарга, нисгэгчид нь зорчигчдоос өмнө агаарын хөлгөөс буух ба завсрын бүсэд хамгаалах хувцас, хэрэгслийг зааврын дагуу тайлж, гарыг халдваргүйжүүлсний дараа халдваргүй бүсэд шилжинэ.
3.2. Агаарын хөлөгт халдварын сэжигтэй тохиолдол илрээгүй нөхцөлд хүндэтгэх шалтгаантай зорчигчдыг эхэлж буулгана.
3.3. Дараа нь гарах хаалганд ойр суудлаас эхлэн дарааллын дагуу зарлаж буулгана.
3.4. Агаарын хөлөгт халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед ойрын хавьтлуудын хамт хойд талын хаалгаар хамгийн эхэнд буулгаж, ХӨСҮТ-ийн шуурхай хариу арга хэмжээний багт хүлээлгэн өгнө.
3.5. Сэжигтэй зорчигч болон ойрын хавьтлуудыг буулгасан хаалгаар бусад зорчигчийг буулгахгүй.
3.6. Зорчигчдыг буулгасны дараа агаарын хөлгийн үйлчлэгч, томилогдсон албан хаагчид бууж, завсрын бүсэд хамгаалах хувцас, хэрэгслийг зааврын дагуу тайлан, гараа халдваргүйжүүлж бэлтгэсэн тээврийн хэрэгсэлд сууна.
3.7. ЗӨСҮТ-ийн шуурхай баг нь зорчигчид, агаарын хөлгийн үйлчлэгч, томилогдсон албан хаагчид бүрэн буусны дараа зорчигчдын ачаа, тээш, гадаад паспорт, зарим шаардлагатай баримт бичиг, агаарын хөлгийн гадна, дотор хэсгийг халдваргүйжүүлнэ.
3.8. Цуглуулсан хог хаягдлыг ЭМС-ын 2017 оны 505 тоот тушаалын дагуу халдваргүйжүүлнэ.
3.9. Хувийн хамгаалах хувцсыг бүрэн, зөв өмсөж, тайлж , эрсдэл үүсээгүй гэж үзсэн тохиолдолд экипажийн бүрэлдэхүүн, томилогдсон албан хаагчийг ажиглалт тусгаарлалт шилжүүлэхгүй байж болно. Энэ асуудал нь олон улсын ачаа тэээврийн жолоочид хувийн хамгаалах хувцсыг иж бүрэн өмсөж эрүүл мэндийн хяналт тавьсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчид мөн хамаарна.